




Ёс зүйн дүрэм

2018 оны хувилбар

JCDecaux

ГҮЙЦЭТГЭХ ЗӨВЛӨЛИЙН ЗАХИДАЛ

Хүндэт Хатагтай, Ноёд, нийт Ажилтнууд танаа,

Салбар нэгж байгуулсан улс орон бүртээ хариуцлагатай, тогтвортой үйл ажиллагаа явуулах нь ЖэйСиДеко Группийн нэн чухал үүрэг билээ. Энэ нь бидний ажилтан, харилцагч, үйлчлүүлэгч, ханган нийлүүлэгч, орон нутгийн буюу бүс нутгийн эрх бүхий байгууллага төдийгүй өрсөлдөгчдийнхөө өмнө хүлээсэн үүрэг, бидний хариуцлага юм. Гагцхүү үүнээс л бидний нэр хүнд болоод хамтран ажиллагч (хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгч, ханган нийлүүлэгч нарыг оролцуулаад) нарын маань бидэнд өгсөн итгэл хамаардаг.

Энэхүү Ёс зүйн дүрмийн эхний хувилбарыг 2001 онд анх эрхлэн гаргасан бөгөөд хожим нь 2005, 2009, 2014 онуудад шинэчлэн найруулсан болно.

2018 оны энэ хувилбарт:

- Ерөнхий менежмент болон Группийн бүх төрлийн авлига хээл хахууль болон албан тушаалын эрх мэдлээ урвуулан ашиглахтай тэмцэх үүргийг баталгаажуулсан,
- Үндэсний хуулиудад орсон өөрчлөлт, тухайлбал 2016 оны 12-р сарын 9-ний өдрийн ил тод байдал, авлигатай тэмцэх болон эдийн засгийн байдлыг шинэчлэх тухай (« Sapin II » гэсэн нэртэй Франц Улсын хуулийн дэлхий дахины хэрэгжүүлэх асуудлыг авч үзсэн, бөгөөд
- Энэхүү Дүрэмд заасан зарчмуудыг илүү амьдралд хэрэгжихүйц болгосон.

Энэхүү Ёс зүйн дүрэмд хавсралтаар шинэ зах зээл буюу шинэ улс оронд үйл ажиллагаа явуулж эхлэх үед Группт үйлчилгээ үзүүлэх, Зөвлөх авч ажиллуулах болон тэдний үйл ажиллагааг зохион байгуулах журмыг оруулсан болно.

Эдгээр өөрчлөлтүүдээс гадна Ёс зүйн үндсэн дүрмийн талаарх зайлшгүй хамрагдвал зохих сургалтыг бий болгосон. Тус сургалт нь Гүйцэтгэх зөвлөл (Executive Board)-ийн нэн тэргүүний зорилго болсон авлига болон албан тушаалын эрх мэдлээ урвуулан ашиглахтай тэмцэх асуудлыг чухалчилж авч үзэх бөгөөд бид эдгээр төрлийн зөрчлийг хэрхэвч хүлээн зөвшөөрөхгүй.

Та бүгдийг манай компанийн үнэт зүйлсийн үндэс болсон өндөр чанар, шударга ёсны зарчмыг бүрнээ дэмжиж байгаа гэдэгт итгэж байна. Гүйцэтгэх зөвлөл эдгээр үнэт зүйлс нь Группийн үйл ажиллагааг чиглүүлэх зарчим байж цаашид мөн энэ хэвээр байлгана гэдгээ баталж байна. Цаашилбал, та бүгдийг анхаарал болгоомжтой, хянамгай байж, Группийн өсөж дээшилсэн түүх, нэр хүндийг энэ чигээр нь хадгалан ажиллана гэдэгт найдаж байна.

Тиймээс энэхүү 2018 оны Ёс зүйн дүрмийг анхааралтай уншиж танилцан, дагаж мөрдөнө үү.

Бид үйл ажиллагаа явуулж буй болон ирээдүйд үйл ажиллагаа явуулах улс орон бүртээ нийгмийн хариуцлагатай хандлагыг баримтлан ажиллах замаар цаашид хамтдаа өсөн дэвшиж, амжилтад хүрэх болно.

Гүйцэтгэх зөвлөл

Жон-Франсуа Деко

Жон-Чарльз Деко

Жон-Себастиан Деко

Эммануэл Бастиид

Дейвид Боург

Даниэл Хотье



| Танилцуулга

Хууль эрх зүй, үйл ажиллагаа, худалдаа арилжаа, нийгмийн харилцаа гээд бүхий л талаараа ээдрээ түвэгтэй олон улсын орчинд мэргэжлийн ёс зүй, Ёс зүйн дүрэм болон Нийгмийн суурь үнэт зүйлсийн Олон улсын дүрэмд заасан зарчмуудыг хүндэтгэн үзэж, хүлээн зөвшөөрч үйл ажиллагаа явуулахаа ЖэйСиДеко Групп мэдэгдэж байна. Бид мөн ажилтнуудаасаа эдгээр зарчмуудыг хүндэтгэн үзэж, дагаж мөрдөхийг хүсэж байна.

Энэхүү Дүрэмд тодорхойлсон зарчмууд нь Групп үйл ажиллагаа явуулж байгаа улс бүрд харилцан адилгүй байх хууль бүрийг дагаж мөрдөхөөс гадна, бүх ажиллагсдынхаа хувийн үзэл бодол, үүрэг хариуцлагаа ухамсарлаж ойлгох асуудлыг хөхиүлэн дэмжихэд чиглэсэн болно.

Гүйцэтгэх зөвлөл нь бүхий л нөхцөл байдалд, ЖэйСиДеко Группийн үйл ажиллагаанд оролцогч талууд, тухайлбал дор дурдсан этгээдүүдийн хоорондын харилцаанд ёс зүйтэй байдлыг эрхэмлэж ажиллахаа илэрхийлсэн билээ. Үүнд:

- › Группийн компани тус бүр болон тэдгээрийн ажилтнууд, болон
- › Ажил хэргийн харилцаатай байдаг компани, хувь хүмүүс, ялангуяа:
- Орон нутгийн болон бүсийн засаг захиргааны байгууллагын ажилтан, албан хаагч, төлөөлөгч,
- Харилцагч, зар сурталчилгааны болон худалдан авалтын төвүүд, болон
- Ханган нийлүүлэгч болон Группээс гадуурх үйлчилгээ үзүүлэгч байгууллагууд.

Ёс зүйн дүрэм нь Гүйцэтгэх зөвлөлөөс ёс зүйн асуудлаар мэдээлэл илгээх, мөн тодорхой нөхцөл байдалд шийдвэр гаргах арга хэрэгслийн үүрэг гүйцэтгэнэ.

Тиймээс Группийн ёс зүйн зарчмуудыг дагаж биелүүлэхийн тулд Дүрмийг сайтар ойлгож, хүлээн зөвшөөрсөн байх нь маш чухал юм. Үүний дагуу Дүрмийг байгууллагын дотор тарааж танилцуулахаас гадна Гүйцэтгэх зөвлөл нь Группийн Хууль зүйн хэлтэст Дүрмийн зарчмууд, тэр дундаа авлига, албан тушаалын эрх мэдлээ урвуулан ашиглахтай тэмцэх тухай зарчмуудыг нийт Группийн хэмжээнд зөв зохистой ойлгож, хэрэгжүүлэх явдлыг ханган ажиллахыг үүрэгдсэн болно.

Энэхүү зорилгын хүрээнд заавал хамрагдах сургалтын системийг боловсруулж, тус сургалтыг олон жилийн хугацаанд цахим-сургалтын хөтөлбөр хэлбэрээр хэрэгжүүлж байгаа бөгөөд цаашид үйл ажиллагааны талаарх холбогдох асуултуудад хариу өгөхөд ашиглахад аль болох хялбар агуулга бүхий тодорхой хөтөлбөрөөр баяжуулж улам төгөлдөржүүлнэ.

Эдгээр сургалтын үйл ажиллагаа нь авлигатай холбоотой нөхцөл байдалтай тулгарч болзошгүй ажилтнуудад голчлон чиглэсэн болно: Гэхдээ илүү олон талт (цахим-сургалт, семинар буюу интернет семинар гэх мэт) хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх зорилго нь дэлхий даяар явагдаж бидний бүхий төрлийн үйл ажиллагааны хүрээнд энэхүү Дүрэмд заасан зохицуулалтын талаар илүү тодорхой ойлголтыг өгөх зорилготой юм.

Ёс зүйн дүрэмд заасан аливаа зарчмын талаар ойлгомжгүй зүйл байгаа тохиолдолд орон нутгийн буюу бүсийн Хууль зүйн хэлтэс эсвэл Группийн Хууль зүйн хэлтэстэй холбогдоно уу.

Хүндэтгэсэн,

Бертранд Аллиан

Группийн Ерөнхий Зөвлөх

ёс зүй



ТОВЧ

I Ёс зүйн дүрэм

1. Ёс зүйн дүрмийн зорилго ба хэрэгжүүлэх хүрээ
2. Дүрмийг түгээх, тараах
3. Мэдээлэх журмууд

II Ёс зүйн үндсэн дүрэм


1. Авлига, албан тушаалын эрх мэдлээ урвуулан ашиглахыг хориглох
Практик заавар - авлига, албан тушаалын эрх мэдлээ урвуулан ашиглахыг хориглох нь
2. Чөлөөт өрсөлдөөний дүрмийг дагаж мөрдөх
Практик заавар - чөлөөт өрсөлдөөний дүрмийг дагаж мөрдөх
3. Санхүү, нягтлан бодох бүртгэлийн холбогдох журмуудыг дагаж мөрдөх
Практик заавар - Санхүү, нягтлан бодох бүртгэлийн холбогдох журмуудыг дагаж мөрдөх

III Группийн Ёс зүйт байдлын зарчмууд

1. Эрх бүхий байгууллагуудтай тогтоох бизнесийн харилцаа
Практик заавар - Эрх бүхий байгууллагуудтай тогтоох бизнесийн харилцаа
2. Үйлчлүүлэгчидтэй тогтоох бизнесийн харилцаа
Практик заавар - үйлчлүүлэгчидтэй тогтоох бизнесийн харилцаа
3. Ханган нийлүүлэгчидтэй тогтоох бизнесийн харилцаа
Практик заавар – ханган нийлүүлэгчидтэй тогтоох бизнесийн харилцаа
4. ЖэйСиДеко Группийн ажилтнуудын эрх, үүрэг
Практик заавар - ЖэйСиДеко Группийн ажилтнуудын эрх, үүрэг

IV Группийн Ёс зүйн хороо

1. Асуудлыг Группийн Ёс зүйн хороонд танилцуулах
2. Мэдээлэл өгсөн ажилтныг хамгаалах
3. Хувийн мэдээллийг хамгаалах
4. Группийн Ёс зүйн хорооны гүйцэтгэх үүрэг
5. Группийн Ёс зүйн хорооны гишүүд, тэдгээрийг томилох
6. Группийн Ёс зүйн хорооны үйл ажиллагаа
7. Гүйцэтгэх зөвлөлд мэдээлэх



Ёс зүйн дүрэм

1. Ёс зүйн дүрмийн зорилго ба хэрэгжүүлэх хүрээ

Энэхүү Ёс зүйн дүрэм (“Дүрэм” гэх)-ийн зорилго нь ЖэйСиДеко Группийн компаниуд, ажилтнууд өөрсдөө болон ажил хэргийн шугамаар хамтран ажиллагч этгээд, компаниудтай холбоотойгоор бүхий л нөхцөл байдалд дагаж мөрдөх дүрмийг тодорхойлоход оршино. Мөн түүнчлэн эдгээр дүрмийг зөрчсөн үйл явдлыг тайлагнах, мэдээлэх журмыг энэхүү Дүрэмд тусгасан болно.

Энэхүү Дүрмийн хүрээнд ЖэйСиДеко Групп гэдэгт ЖэйСиДеко ЭсЭй, түүний шууд буюу шууд бус охин компаниуд болон ЖэйСиДеко ЭсЭй шууд буюу шууд бусаар бага хэмжээний хувьцаа эзэмшдэг боловч түүний тусгай буюу хамтарсан удирдлагад багтдаг бүх компаниуд (цаашид “ЖэйСиДеко Групп” эсвэл “Групп” гэх)-ыг багтааж ойлгоно.

2. Дүрмийг түгээх, тараах

2.1 Дүрмийг

- Ажилтан бүрийг ажилд орох үед түүний хөдөлмөрийн гэрээний нэг хэсэг болгон өгнө,
- Группийн дотоод сүлжээнээс эсвэл Группийн компани тус бүрийн Хүний нөөцийн хэлтэст хандаж авах боломжтой байна,
- Группийн ажилтан бус Агентууд, зөвлөх, Зуучлагч (Зар сурталчилгааны байгууллагууд) нартай байгуулах гэрээнд тухайн этгээдүүдийг авч ажиллуулахад баримтлах бие даасан журамд заасанчлан системчилсэн байдлаар хавсаргасан байна.

ЖэйСиДеко ЭсЭй болон түүний нэгдмэл сонирхолтой этгээдүүдийн гүйцэтгэх удирдлага болон менежерүүд Ёс зүйн дүрмийг байнга мөрдөж ажиллах болон ажилтнуудад тарааж, танилцуулах үүрэгтэй. Дагаж мөрдөн, биелүүлэх үүрэгтэй ЖэйСиДеко Группийн ёс зүйн дүрмүүдийг ойлгож, хэрэгжүүлэх чадварыг эзэмшсэн эсэхээ үнэлүүлэх хүртэл нь аливаа ажилтныг удирдлагын албан тушаалд томилохгүй.

2.2 ЖэйСиДеко Групп компаниудын Ерөнхий менежерүүд Дүрмийг тараах шаардлагын хэрэгжилтийн тайланг жил бүр гаргах үүрэгтэй.

2.3 ЖэйСиДеко Группийн Хууль зүйн хэлтэс болон Дотоод аудитын хэлтэс дээр дурдсан Дүрмийг тараах шаардлагын хэрэгжилтийг шалгаж, хангаж ажиллана.

3. Мэдээлэх журмууд

Та энэхүү Дүрэмд заасан зарчмуудыг зөрчсөн нөхцөл байдлын талаар олж мэдсэн бол дараах мэдээлэх журам нь тухайн зөрчил гаргасан нөхцөл байдлыг зохих хууль, тогтоомж, мөн мөрдөгдөж буй практикын дагуу таны хувийн санал бодол, нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээнд түшиглэн шийдвэрлэх боломжийг олгоно.

3.1 Ёс зүйт байдлын зарчмуудыг зөрчих

Хэрэв тухайн үйл явдал Групп компанийн Ёс зүйт байдлын зарчмыг биелүүлээгүйтэй холбоотой нөхцөл байдлаас үүссэн бол холбогдох ажилтны захирал эсвэл шууд удирдах ажилтанд мэдээлнэ.

Хэрэв мэдээлэл өгч буй этгээд нь өөрийн захиралдаа мэдээлэх нь хүндрэл бий болгож болзошгүй эсвэл зохих арга хэмжээ авахгүй байж болзошгүй гэж үзвэл тухайн улсыг хариуцсан Ерөнхий менежер эсвэл бүс нутгийн Ерөнхий менежерт мэдээлж болно.

Мэдээлэл хүлээн авсан этгээд нь хэрэгжүүлэх шаардлагатай хяналт шалгалтын ажиллагаа, засах арга хэмжээг тодорхойлох үүрэгтэй.

Ямар ч тохиолдолд ЖэйСиДеко Групп нь шударгаар мэдээлсэн аливаа ёс зүйн алдаа зөрчлийг нягтлан шалгаж, засаж залруулах буюу тогтоогдсон тохиолдолд тухайн алдааг засах шийдлийг эрэлхийлэх болно.

3.2 Ёс зүйн үндсэн дүрмүүд

Ёс зүйн үндсэн дүрмүүдийн аливаа бий болж болзошгүй зөрчлийг (авлига/албан тушаал эрх мэдлээ урвуулан ашиглах, чөлөөт өрсөлдөөн, санхүү болон нягтлан бодох бүртгэл гэх мэт) мөнхүү зорилгоор бий болгосон ёс зүйн зөрчлийг мэдээлэх журмын дагуу Группийн Ёс зүйн хороонд мэдээлж болох бөгөөд тухайн мэдээлсэн зөрчил нь тогтоогдсон бол сахилгын шийтгэл ногдуулж болно.

Группийн Ёс зүйн хорооны Гишүүнчлэл, дотоод журмыг IV хэсэгт тодорхойлсон болно.

Ёс зүйн үндсэн дүрмүүд гэдэг нь зөрчигдсөн тохиолдолд Группийн одоо явуулж буй эсвэл ирээдүйд явуулах үйл ажиллагаанд ноцтой хэмжээний нөлөө үзүүлэх дүрмүүдийг хэлнэ. Эдгээр дүрмийн зөрчлийг арилгах, холбогдох хяналт шалгалт хийх болон санал зөвлөмж гаргах асуудал нь ЖэйСиДеко Эсэй-ийн хэрэгжүүлэгч хэсэг болох Группийн Ёс зүйн хорооны бүрэн эрхэд хамаарна.



II Ёс зүйн үндсэн дүрэм

Ёс зүйн үндсэн дүрмүүд нь:

- › Авлигыг хориглох,
- › Чөлөөт өрсөлдөөний зарчмыг дагаж мөрдөх,
- › Санхүү, нягтлан бодох бүртгэлийн журмуудыг дагаж мөрдөх болно.

1. Авлига, албан тушаалын эрх мэдлээ урвуулан ашиглахыг хориглох

1.1 Бүх хэлбэрийн авлигыг хориглох

Авлига, хээл хахууль авсан, өгсөн, албан тушаал, эрх мэдлээ урвуулан ашигласан үйлдэл хийсэн эсвэл гуравдагч этгээдийг өөрийн нэрийн өмнөөс авлига, албан тушаалын эрх мэдлээ урвуулан ашиглах үйлдэл хийхээс сэргийлж чадаагүй компани нь:

- › Нэр хүндээ алдаж,
- › Орон нутгийн төрийн байгууллагаас зарласан тендерийн шалгаруулалт эсвэл гэрээнд оролцуулах эрхээ алдах гэх мэтээр санхүүгийн ноцтой хориг тавигдах эрсдэлд орж,
- › Ажилтнуудад (бие даасан байдлаар) нь эрүүгийн хариуцлага, тухайлбал хоригдох ял хүлээлгэхэд хүргэж болзошгүй.

Авлига гэж юу вэ?

“Идэвхтэй авлига” гэж төрийн албан хаагч эсвэл ажилтныг ажил үүргээ гүйцэтгэхдээ аливаа үйлдлийг хийх эсвэл хийхгүй байлгах зорилгоор төрийн албан хаагч, хувийн компанийн албан тушаалтан, ажилтанд өөрийнхөө болон бусад этгээдийн төлөө шууд буюу шууд бусаар хууль бус давуу байдал олгох, мөн тухайн давуу байдлыг олгохыг амлах эсвэл давуу байдал санал болгохыг хэлнэ.

Үүнд төрийн албан хаагч эсвэл ажилтны хамаатан садан, холбоотой этгээдэд эсвэл түүний зааж өгсөн аливаа бусад этгээдэд шууд эсвэл гуравдагч этгээдээр дамжуулж шууд бусаар давуу байдал олгохыг багтааж ойлгоно.

Албан тушаалын эрх мэдлээ урвуулан ашиглах гэж юу вэ?

Албан тушаал, эрх мэдлээ урвуулан ашиглах гэж төрийн албан тушаал хашиж байгаа эсвэл төрийн албаны эрх үүрэг шилжүүлэн авсан, эсхүл төрийн албанд сонгогдсон этгээд өөрийнхөө эсвэл бусад этгээдийн ашиг сонирхлын төлөө шууд буюу шууд бусаар санал, амлалт, хандив, бэлэг, давуу байдал хүсэх эсвэл зөвшөөрөх, аливаа эрх бүхий байгууллага эсвэл төрийн захиргааны байгууллагаас шагнал, албан тушаал, зах зээл олж авах эсвэл өөрт ашигтай аливаа бусад шийдвэр гаргуулахын тулд өөрийн бодит эсвэл өөртөө байгаа гэж ойлгосон эрх мэдлийг урвуулан ашиглах хууль бус үйлдлийг хэлнэ.

1.2 Бидний үүрэг

ЖэйСиДеко Групп нь бүх төрлийн авлига эсвэл албан тушаалын эрх мэдлээ урвуулан ашиглахыг хатуу хориглодог.

Энэхүү үүргээ дагаж биелүүлэх нь ЖэйСиДекогийн үндсэн үүрэг хариуцлага бөгөөд эдгээр үүрэг нь:

- бизнесийн харилцаанд ёс суртахууны стандартыг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэх, мөн
- бидний одоо эсвэл ирээдүйд үйл ажиллагаа явуулах бүх улс орнуудад өөрсдийн богино болон урт хугацааны ашиг сонирхлыг хамгаалахад шаардлагатай юм. Групп компанийн зүгээс энэ талаар бусдад үлгэр дуурайлал болох зорилго тавьж байна.

1.3 Урилга болон бэлэг

Аливаа урилга, бэлгийг гагцхүү төрийн албан хаагч эсвэл хувь хүнд холбогдох тухайн орны хууль тогтоомж болон өөрсдийн дагаж мөрдөх үйл ажиллагааны дүрмийн дагуу өгөхийг зөвшөөрнө. Ямар ч тохиолдолд тендер шалгаруулалтын үед урилга, бэлэг өгөхийг хориглоно.

Групп компани нь дэмжлэг үзүүлсний төлөө төлбөр төлөхийг хүлээн зөвшөөрөхгүй.

1.4 Төлөөлөгч, зөвлөх, зуучлагч ашиглах

Төлөөлөгч, зөвлөх, зуучлагч ажиллуулах асуудалд хатуу хяналт тавих бөгөөд зайлшгүй авах шаардлагатай тохиолдолд үйлчилгээ авна. Эдгээр этгээдэд олгох цалин урамшуулал нь компанид мэдэгдэхгүй байдлаар шууд бус хэлбэрийн авлигад тооцогдох эрсдэлд хүргэж болно. Групп компанийн бүх ажилтнууд нь энэ асуудалд анхаарал болгоомжтой хандах шаардлагатай.

1.5 Улс төрийн намуудыг санхүүжүүлэх

Групп компани нь улс төрийн нам, улс төрчдийг санхүүжүүлэхгүй байх ерөнхий бодлого баримталдаг. Группийн Ерөнхий менежмент энэхүү бодлого хамаарахгүй нөхцөл байдлуудын жагсаалтыг гаргасан байх шаардлагатай. Зөвшөөрөгдсөн хандивыг холбогдох улсын хуулийн дагуу гүйцэтгэнэ. Тухайлбал хэрэв уг хандивыг хуулиар зөвшөөрсөн бөгөөд Группийн Ерөнхий менежментээс зөвшөөрсөн тохиолдолд хуулиар шаардсан бүх мэдэгдэл, бүртгэлийг хийлгэж байж хандив өгнө. Групп өөрийн ажилтнуудын улс төрд хувь хүний хувьд оролцох эрхийг хүндэтгэн үзэх нь мэдээж боловч тухайн оролцоо цэвэр хувийн шинжтэй байна.



Практик заавар:

Өндөр эрсдэлтэй нөхцөл байдал / хэрэгжүүлэх үйлдэл

Авлига, албан тушаалын эрх мэдлээ урвуулан ашиглахыг хориглох

1. Төрийн албан хаагч гэж хэн бэ?

“Төрийн албан хаагч” гэдэг ойлголтыг дэлгэрэнгүй тодорхойлсон байдаг бөгөөд энэ нь ерөнхийдөө аливаа засгийн газар, олон нийтийн эсвэл олон улсын агентлаг, байгууллага, орон нутгийн холбоо, хотын албан хаагч, албан тушаалтан, ажилтан, аливаа сонгогдсон төлөөлөгч, хуулийн байгууллагад албан тушаал хашиж буй этгээд, эсвэл эдгээр байгууллагаас авсан үйлчилгээнээс ашиг хүртэж буй аливаа этгээдийг хэлнэ.

2. Хатуу, чанд, олон улсын шинжтэй хуулийн хамрах хүрээ

Бидний үйл ажиллагаа явуулж буй улс орон бүр төрийн албан хаагч болон хувь хүний авлига хээл хахуультай тэмцэх тухай хуультай байдаг.

Олон улсын тавцанд дөчин улс Эдийн засгийн хамтын ажиллагаа хөгжлийн байгууллага (OECD)-аас 1997 оны 9-р сарын 17-ны өдөр баталсан гадаадын төрийн албан хаагчид авлига өгөхтэй тэмцэх тухай конвенцид нэгдэн орсон бөгөөд улс бүр тухайн конвенцид заасан үйлдэлд ногдуулах шийтгэлийн тухай дотоодын хууль батлан гаргасан байна.

Европын холбооны 1999 оны Авлигын талаарх эрүүгийн эрх зүйн конвенц, 1996 оны Авилгын эсрэг Америк тивийн улсуудын конвенц болон Нэгдсэн Үндэстний байгууллагын 2003 оны конвенц нь төрийн албан хаагч болон хувийн хэвшлийн ажилтнуудын авлигын хэрэгтэй тэмцэх асуудлыг нэн тэргүүний олон улсын зорилт болгон тодорхойлсон байна. Олон улс орон эдгээр конвенцийг өөрийн дотоодын эрүүгийн хуульдаа суулган тусгаж өгсөн байна.

Үүний үр дүнд үндэсний хууль тогтоомжууд нь гадаадын төрийн албан хаагчийн авлига авах үйлдлийг ч мөн багтаан хориглох болсон байна.

Олон улсын авлигын зохицуулалтыг тусгасан үндэсний хууль тогтоомжуудад дараах хуулиуд орно. Үүнд:

- Франц Улсын хувьд 2000 оны 6-р сарын 30-ны өдөр батлагдаж, гадаадын төрийн албан хаагчийн авлигын гэмт хэргийг Францын төрийн албан хаагчийн авлигын хэрэгт нэмж оруулсан 2007 оны 11-р сарын 13-ны өдөр нэмэлт өөрчлөлт, мөн ойрын хугацаанд гэвэл авлига, албан тушаалын эрх мэдлээ урвуулан ашиглах, мөн түүнчлэн урьдчилан сэргийлэх арга хэмжээ аваагүйтэй холбоотой хяналт, шийтгэлийг хэмжээг нэмэгдүүлж, шинээр байгуулагдсан бие даасан захиргааны байгууллагад (Франц Улсын Авлигатай тэмцэх газар-l'Agence Française Anticorruption) эдгээр асуудлыг хариуцуулсан 2016 оны 12-р сарын 9-ний өдрийн ил тод байдал, авлигатай тэмцэх болон эдийн засгийн байдлыг шинэчлэх тухай (« Sapin II » гэсэн нэртэй) хууль,
- АНУ-ын хувьд, гадаадын төрийн албан хаагчдын авлигын хэргийг гэмт хэрэг гэж үзэн шийтгэх тухай 1977 батлагдаж, 1998 онд нэмж дэлгэрүүлсэн Гадаад улс дах авлигын хэргийн тухай акт (“ГУДАХТА”) тус тус болно.

Америкийн Нэгдсэн Улс нь ГУДАХТА -ын хүрээнд олон улсын авлигатай тэмцэх талаар маш идэвхтэй бодлого хэрэгжүүлж байна. Хэрэв нэг буюу түүнээс олон удаагийн авлигын хэрэг нь АНУ-тай холбоотой тохиолдолд энэхүү хууль нь АНУ-ын иргэн, оршин суугч болон

оршин суугч биш этгээдүүдэд үйлчлэх болно. АНУ-тай холбоотой гэсэн энэ санааг өргөн хүрээнд тайлбарладаг.

➤ Франц Улсын 2016 оны Sapin II гэх хууль болон ИБУИНВУ-ын 2010 оны Авлигатай тэмцэх тухай хуулиудыг АНУ-ын ГУДАХТА-аас санаа авч баталсан боловч эдгээр шинэ хуулиуд нь илүү өргөн хүрээг хамарч, авилгаас урьдчилан сэргийлэх болон тэмцэх талаар илүү үр дүнтэй арга хэмжээ авах шаардлагыг компаниудад тавьсан байна.

Британи болон Францын авлигатай тэмцэх тухай хуулиудад гаалиар бараа нэвтрүүлэх гэх мэтийн захиргааны үйл явцыг түргэвчлүүлэхэд зарим тохиолдолд ашигладаг бага хэмжээний дэмжлэг үзүүлсний төлбөр эсвэл «гар хүндрүүлэх» төлбөрийг зөвшөөрсөн зохицуулалт байхгүй.

3. Авлига, албан тушаалын эрх мэдлээ урвуулан ашиглахтай тэмцэх тухай зарчмыг дагаж биелүүлэх

Орон нутгийн засаг захиргаа, засгийн газартай харилцахдаа шударга, үнэний хамгийн нарийн зарчмыг баримтлах шаардлагатай. Бизнесийн орчинд хүлээн зөвшөөрөгдөж болох зүйл нь төрийн албан хаагчтай харилцах харилцаанд хүлээн зөвшөөрөгдөхгүй эсвэл бүр эрүүгийн гэмт хэрэг болж шийтгэл хүлээхэд ч хүргэж болно.

Хүлээн зөвшөөрөгдөх стандарт болон авлига, албан тушаалын эрх мэдлээ урвуулан ашиглахын хоорондын зааг ялгаа заримдаа тодорхойгүй байдаг бөгөөд тухайн улс орон, цаг хугацаанаас хамаарч харилцан адилгүй байж болно. Дараах 2-р хэсгийг ийм нөхцөл байдалд хэрэглэх гарын авлага болгон ашиглах нь зүйтэй.

4. Хүлээн зөвшөөрөгдөх тогтсон практик ба авлига, албан тушаалын эрх мэдлээ урвуулан ашиглах үйлдлийн зааг ялгаа

Авлигатай тэмцэх тухай болон албан тушаалын эрх мэдлээ урвуулан ашиглахтай тэмцэх тухай хуулиудад «төлөөлөл ба урамшууллын хөлс» –ийн талаар тодорхой зүйл огт дурдаагүй байдаг учраас үүнийг зөвшөөрөх эсэх, ямар хэмжээтэй байх тухай тодорхойгүй асуудал байсаар байна.

Британийн Хууль зүйн яамнаас 2011 онд хэвлүүлэн гаргасан Худалдааны байгууллагуудын Гарын авлага (“ХБГА”)-д энэхүү зааг ялгааг тодорхой болгох оролдлого гаргажээ. Гэвч энэ нь мэдээллийн чанартай баримт бичиг бөгөөд үндэслэл, хувь хэмжээ болон зарцуулах үндэслэлийн талаар асууж тодруулах үүрэгтэй гэж заасан байна.

ХБГА-ын дагуу хэрэв төлөөлөл, дэмжлэгийн хөлс төлбөрийг аливаа шийдвэр гаргах эрх бүхий этгээдэд нөлөө үзүүлэх зорилгоор өгсөн тохиолдолд тэдгээр нь авлигад тооцогдоно гэж тодорхой заажээ.

Гэхдээ ХБГА-ын дагуу нөхөрсөг харилцаа үүсгэж, харилцаагаа хэвээр хадгалах, компанийн нэр хүндийг өсгөх, бүтээгдэхүүнийг сурталчлах зорилгоор өгсөн зарим төлөөлөл, дэмжлэгийн төлбөрийг хууль ёсны гэж үзэж болох хэдий ч тухайн төлбөрийн зөвшөөрөгдөх хэмжээ нь тодорхойгүй байгаа тул уг төлбөрийг хийхдээ туйлын анхааралтай байвал зохино.

Иймд ХБГА-аас практик жишээнээс дурдсан байдаг:

➤ Бүх оролцогч талуудын төлөвлөгөө, хуваарийг авч үзвэл тэдний хувьд хамгийн боломжит шийдвэр байх тохиолдолд ч Групп компанийн дээд удирдлагын ажилтнуудтай уулзуулах зорилгоор гадаадын албан тушаалтан эсвэл хувь хүний тансаг, алдартай газар руу зорчих замын зардал, байр хоолны зардлыг төлөх нь маш өндөр эрсдэлтэй үйлдэл болох юм.

- Хэрэв Групп компани эсвэл охин компанийн төв салбар дээр уулзахаар урьсан бол, гаргасан зардлын үндэслэл, хувь хэмжээ нь тухайн уригдсан этгээдийн ердийн амьжиргааны түвшинд нийцсэн байх шаардлагатай бөгөөд тухайн урилгын зорилго нь үйл ажиллагаатай (компанийн ажлын байр, талбарт зочлох, бүтээгдэхүүн сурталчлах гэх мэт. Гэхдээ холбогдох хугацаа үйл ажиллагааны хэрэгцээ шаардлагаас хэтэрсэн байж болохгүйг анхаарна уу) холбоотой байх шаардлагатай.
- Төрийн албан хаагч, эсвэл хувь хүний замын зардал, байр хоолны зардлыг хариуцан төлж аливаа спорт, урлагийн үйл ажиллагаанд оролцуулах нь хэрэв тухайн үйл ажиллагаанд Групп компани эсвэл түүний охин компани бизнесийн хамааралгүй (жишээ нь тухайн үйл ажиллагааг ивээн тэтгэгч, албан ёсны ханган нийлүүлэгч, хамтран ажиллагч биш байх тохиолдолд) бөгөөд хэрэв тухайн үйл ажиллагаанд урьж оролцуулах зардал нь тухайн уригдсан этгээд өөрөө тухайн ажиллагаанд оролцохдоо зарцуулах байснаас их байсан тохиолдолд өндөр эрсдэлтэйд тооцогдоно.

Бид тухайн үйлдэл нь төрийн албан хаагчид нөлөөлөх эсэх, төрийн албан хаагчийг зохисгүй үйлдэл хийхэд эсвэл өөрийн бүрэн эрхийн хүрээнд хамаарах үйлдэл, эс үйлдэхгүйгээ гүйцэтгэхгүй байхад хүргэх эсэх, эсвэл ийм үйлдэл хийснийх нь төлөө урамшуулсан эсэхийг байнга, сайтар анхаарч, харгалзан үзэх үүрэгтэй.

Ийнхүү анхаарал болгоомжтой байх нь авлига, албан тушаалын эрх мэдлээ урвуулан ашиглах асуудлыг тодорхойлоход үндсэн үүрэг гүйцэтгэнэ.

Хэрэв таныг төрийн албан хаагчаас аливаа хууль бус давуу байдал олж авахыг шаардсан тохиолдолд ийм шаардлагаас татгалзах асуудлыг хариуцаж буй өөрийн менежертээ нэн даруй мэдэгдэх шаардлагатай.

ЖэйСиДеко Групп нь аливаа хэлбэрийн давуу байдал олж авахын тулд мөнгө төлөхийг шаардсан аливаа төрийн албан хаагчийн шаардлагыг хүчээр биелүүлэх нөхцөл байдалд орсноос тендер эсвэл гэрээнд оролцох урилгаас татгалзах нь илүү дээр шийдэл гэж үздэг.

5. Бэлэг болон урилга

Бэлгийг зар сурталчилгааны танилцуулах зорилготой бүтээгдэхүүн, үйлчилгээнээс ялгаж үзэх шаардлагатай.

- Сурталчилгааны зүйлс гэдгийг үнэ төлбөргүй (100 ам.доллар хүртэл эсвэл тухайн улсаас хамаарч тогтоосон үүнээс доош үнэтэй), ЖэйСиДекогийн нэрийг арилахгүй байхаар бичсэн зүйл гэж тодорхойлдог.
- Бэлэг нь дээрхтэй адил хэмжээтэй бөгөөд албан бус бөгөөд цаг хугацаатай үйл явдлуудад (хурим, төрсөн өдөр гэх мэт) зориулсан байх шаардлагатай бөгөөд бэлгийг гагцхүү онцгой тохиолдолд өгөхийг зөвшөөрнө.
- Хэмжээ эсвэл зорилгоос үл хамаарч мөнгөн хэлбэрийн буюу мөнгөтэй адилтгах зүйлээр илэрхийлсэн бэлэг өгөхийг хориглоно.

Урилгыг нууцлалтайгаар өгөхгүй.

Групп компанийн Ерөнхий менежмент урилга өгөх эсэхийг зөвшөөрсөн байх шаардлагатай бөгөөд урилгын шинж байдал, аяллын хөтөлбөрийг зохих ёсоор хадгалж, уригдсан этгээдийн нэрийг тодорхой дурдсан байна.

Энэ асуудалд хулиар аливаа хязгаарлалт тогтоогоогүй. Гэхдээ урилга нь (зорчих аялах тухайд) үндэслэлтэй, шударга, хууль ёсны байх шаардлагатай бөгөөд эдгээр шаардлагыг хатуу тайлбарласан байна.

Тиймээс зохих зорилготой, үндэслэл бүхий урилга өгөхийг зөвшөөрөх боловч хэрэв урилгыг төрийн албан хаагч эсвэл хувь хүнд байнга өгдөг (нэг удаагийн урилга бус) бол “хууль бус”-д тооцогдож, авлига өгсөн үйлдэл болох боломжтой.

АНУ болон зарим бусад улсын хуульд төрийн албан хаагчид урилга, хэмжээнээс үл хамаарч аливаа бэлэг өгөхийг албан ёсоор хориглосон байдаг. Ийм илүү хатуу хязгаарлалт тогтоосон бол тухайн улсын хуулийг дагаж мөрдөнө. Тиймээс аливаа урилга хүлээн авахаасаа өмнө тухайн урилгыг холбогдох хуулиар зөвшөөрөх эсэхийг нягтлан үзэх шаардлагатай.

6. Төлөөлөгч, зөвлөх болон зуучлагч ажиллуулах

Төлөөлөгч, зөвлөх, зуучлагчийн явуулж буй эсвэл явуулах боломжтой үйл ажиллагаанд санаатайгаар хайхрамжгүй хандсан бөгөөд төлөөлөгч авлига өгсөн бол санаатай хайхрамжгүй байдал нь гэмт хэрэгт холбогдохоос хамгаалах үндэслэл болохгүй.

Бид ийм нөхцөл байдлаас зайлсхийх үүднээс зохих урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах үүрэгтэй.

Төрийн албан хаагчид аливаа шууд бус хэлбэрийн авлига өгөхөөс зайлсхийх зорилгоор Зөвлөх ажиллуулах ба түүний үйл ажиллагааг зохион байгуулах тухай Группийн дотоод журмыг үзнэ үү. Энэхүү журамд авлигатай тэмцэх асуудлаар олонд танигдсан төрийн бус байгууллага болох Транспэрэнси Интернэшнлээс олон улсын хэмжээнд улс орон бүрээр тодорхойлсон авлигын төсөөллийн эрсдэлийн түвшинг харгалзан үзсэн байна.

7. Улс төрийн нам/сайн санааны буяны үйл ажиллагааг санхүүжүүлэх

7.1 Улс төрийн нам эсвэл улс төрийн намуудтай холбоотой холбоо/санг санхүүжүүлэх асуудлыг улс орон бүрийн хуулиудад харилцан адилгүй зохицуулсан байдаг. Хуулийн дагуу зөвшөөрсөн тохиолдолд ч ийм төрлийн хандивыг сэжигтэй үйл ажиллагаа гэж буруугаар ойлгуулах буюу тайлбарлах асуудал гарч болно.

7.2 Хэрэв сайн санааны болон сайн дурын үйл ажиллагаа нь олон нийтийн эрх ашгийн төлөө бөгөөд олон нийтийн оролцоог бодитоор хангахад хувь нэмэр оруулах тохиолдолд ийм төрлийн үйл ажиллагаанд хандив өргөхийг зөвшөөрнө.

Ийм төрлийн хандивыг өгөхдөө холбогдох Групп компанийн менежерээс урьдчилан бичгээр зөвшөөрөл авч, зохих ёсоор бүртгүүлнэ.

Аливаа үйлдлийн талаар эргэлзээтэй зүйл байвал харьяа Хууль зүйн хэлтэс, бүсийн Хууль зүйн хэлтэс эсвэл Групп компанийн Хууль зүйн хэлтэстэй цаг адалгүй холбогдож тухайн нөхцөл байдлын талаарх хуулийн зөвлөгөө авна уу.

2. Чөлөөт өрсөлдөөний дүмийг дагаж мөрдөх

ЖэйСиДеко Групп нь өрсөлдөөний дүмийг дагаж биелүүлэхэд онцгой ач холбогдол өгдөг.

2.1 Журмуудыг дагаж мөрдөх

Та үйл ажиллагаа явуулж буй зар сурталчилгааны зах зээлийн газар зүйн байрлалаасаа үл хамаарч өөрийн өрсөлдөгчидтэй харилцах харилцаанд баримтлах өрсөлдөөний дүмийг сайтар мэдэж, тэдгээрийг дагаж мөрдөх үүрэгтэй.

Групп компанийн үйл ажиллагаа явуулж буй бараг бүх улс өрсөлдөөний дүрэмтэй бөгөөд тэдгээр нь дараах нийтлэг агуулгатай байдаг. Үүнд:

- › Компаниуд өрсөлдөөнийг хязгаарлахад чиглэсэн, хязгаарлахад хүргэх эсвэл хязгаарласан бичгээр эсхүл бусад хэлбэрээр үйлдсэн гэрээг байгуулахыг хориглодог, болон
- › Давамгай байдлаа буруугаар ашиглахыг хориглодог.

Европт эдгээр дүмийг Европын холбооны Гэрээний 101 болон 102-р зүйлд тодорхойлсон байдаг бөгөөд Европын холбооны гишүүн орнуудын тус тусын хуулиудад тусгаж оруулсан байна.

2.2 Хориглосон үйл ажиллагаа

Хууль бус гэрээ болон давамгай байдлаа хууль бусаар ашиглах гэсэн өрсөлдөөний эсрэг үндсэн хоёр төрлийн үйл ажиллагаа байдаг. Хэрэв ийм гэрээ чөлөөт өрсөлдөөнийг хязгаарлаж байгаа бол эдгээр хориглосон үйлдэл дан ганц өрсөлдөгчдөд хамааралтай бус мөн ханган нийлүүлэгч болон үйлчлүүлэгчдэд ч хамааралтай.

2.2.1 Хууль бус гэрээ болон мэдээлэл солилцох

Зах зээлийн хэвийн нөхцөл байдалд нийцэхгүй өрсөлдөөнийг бий болгох зорилгоор зах зээлд аж ахуй эрхлэгчдийн хооронд аливаа бичгээр эсвэл амаар шууд буюу шууд бус гэрээ байгуулахыг хориглоно.

Хууль бус гэрээнд тооцогдохгүй байсан тохиолдолд ч өрсөлдөгчид хоорондоо чөлөөт өрсөлдөөнийг хязгаарласан нууц мэдээлэл солилцохыг хориглоно.

Дараах Зааврыг үзнэ үү.

2.2.2 Давамгай байдлаа буруугаар ашиглах.

Аливаа компани нь зах зээлд давуу байдалтай байж, мөн тендерийн шалгаруулалтад ялалт байгуулах замаар зах зээлд хувь оролцоогоо өсгөх замаар өөрийн давамгай байдлыг нэмэгдүүлж болно. Үүнийг хууль бусад тооцохгүй.

Харин тухайн зах зээлд чөлөөт өрсөлдөөнийг хязгаарлах зорилгоор өөрийн давамгай байдлыг буруугаар ашиглахыг хориглоно.

2.3 Шийтгэл

2.3.1 Холбогдох хуулийг зөрчсөн тохиолдолд дараах шийтгэлийг ногдуулна. Үүнд:

- › Санхүүгийн шийтгэл:

Европт ийм төрлийн шийтгэл нь дэлхийн даяар явуулж буй үйл ажиллагааны эргэлтийн хөрөнгийн 10% хүртэл хэмжээтэй байж болно. Европын хууль нь Групп компани үйл ажиллагаа явуулж буй улсуудын дотоодын хуульд нэмэлт болох бөгөөд өрсөлдөөний тухай дотоодын хуулиудыг зөрчих нь тухайн хууль үйлчлэх нэг бус улсад хариуцлага хүлээхэд хүргэж болно. Энэхүү хариуцлагад засгийн газартай байгуулах гэрээнд оролцохыг бүрмөсөн хориглох зэрэг шийтгэл багтаж болно.

› Эрүүгийн гэмт хэргийн шийтгэл:

Зарим улсад өрсөлдөөний тухай хуулийг ноцтой зөрчсөн хувь хүмүүст торгууль ногдуулах эсвэл хорьж шийтгэх хүртэл арга хэмжээ авч болдог.

2.3.2 Цаашилбал, өрсөлдөөний тухай хуулийг зөрчих нь:

- › Өмгөөллийн хөлсөнд хууль зүйн их хэмжээний зардал гаргах, мөн компанийн мөнгөн хөрөнгөөс их хэмжээгээр зарцуулах шаардлагатай байдалд оруулах захиргааны болон хууль зүйн мөрдлөг шалгалт хийхэд хүргэж болно.
- › Компанийн нэр хүндэд сөргөөр нөлөөлнө.
- › Гуравдагч этгээд холбогдох үйл ажиллагааны улмаас өөрт учирсан хохирлоо төлүүлэхээр нэхэмжлэл гаргаж болно.

Тиймээс харьяа Хууль зүйн хэлтэс, бүсийн Хууль зүйн хэлтэс, Групп компанийн Хууль зүйн хэлтсээс холбогдох хууль, журмын талаар мэдээлэл авах нь зүйтэй юм.





Практик заавар:

Өндөр эрсдэлтэй нөхцөл байдал / хэрэгжүүлэх үйлдэл

Чөлөөт өрсөлдөөний дүрмийг дагаж мөрдөх

1. Өрсөлдөгчидтэй харилцах харилцаа

1.1 Хууль бус гэрээ болон мэдээлэл солилцох

Зар сурталчилгаа явуулж буй зах зээлийн чөлөөт өрсөлдөөнийг хязгаарлаж болзошгүй тул өрсөлдөгчидтэй байгуулах гэрээ нь маш эмзэг асуудал юм.

ЖэйСиДеко Группийн ажилтнууд дараах сэдвээр өрсөлдөгч компаниудтай амаар болон бичгээр хэлэлцэж ярилцахгүй. Үүнд:

- Үнэ тогтоох асуудал: Зар сурталчилгаа явуулж буй, худалдагч талуудтай холбоотой үнэ, тендерийн үнийн санал эсвэл эдгээртэй адил үнэтэй хамааралтай эсэхээс үл хамаарч аливаа төрлийн үнэтэй холбоотой (тариф, хөнгөлөлт, үнэ тогтоох аргачлал гэх мэт) гэрээ байгуулахыг хориглоно.
- Тендерийн луйвар: аливаа тендер эсвэл бусад хэлцлийн хүрээнд аливаа хэлбэрийн зах зээлийн хуваарилалт хийхийг хориглоно.
- Санхүүгийн мэдээлэл солилцох: өрсөлдөгчид хоорондоо нийтэд нээлттэйгээс бусад санхүүгийн мэдээллийг солилцох эрхгүй. Үүнд ашиг, худалдаж авсан эсвэл үйлдвэрлэсэн бараа, үйлчилгээний зардлын тухай мэдээлэл (Групп компанийн нийтэд мэдээлсэн санхүүгийн тайланд тусгаснаас бусад), мөн дараах төрлийн худалдаа, зах зээлийн мэдээллийг солилцохыг багтаана. Үүнд:
- Нууц бөгөөд нарийвчлан тодорхойлсон мэдээлэл (жишээ нь маркетингийн төсөл болон маркетингийн стратеги гэх мэт),
- Компаниас нийтэд мэдэгдээгүй байгаа мэдээлэл (жишээ нь худалдаж авсан бараа, үйлчилгээний үнэ, захиалгын хэмжээ, сүлжээ эсвэл хот бүрийн эргэлтийн хэмжээ, бодитоор олгосон хөнгөлөлтийн тухай мэдээлэл).

Тиймээс үйл ажиллагаа явуулж буй улсынхаа холбогдох хууль тогтоомжийг сайтар судалж мэдэх хэрэгтэй бөгөөд хэрэв аливаа үйлдэл эргэлзээтэй санагдсан тохиолдолд харьяа Хууль зүйн хэлтэс, бүсийн Хууль зүйн хэлтэс, Групп компанийн Хууль зүйн хэлтсээс зөвлөгөө авах нь зүйтэй.

Хурал, семинар болон эвлэлийн уулзалтууд нь өрсөлдөгчдийн уулзах газар байдаг. Сонор сэрэмжтэй бай. Хэрэв аливаа өрсөлдөгч уулзалтын үед өрсөлдөөний тухай хуулийг зөрчсөн асуудлыг дэвшүүлсэн тохиолдолд түүнд саад хий эсвэл уулзалтыг орхиж гарч болох бөгөөд харин явж буй тухайгаа зохих ёсоор мэдэгдээрэй.

1.2 Давамгай байдлаа хууль бусаар ашиглах

Зарим улсад өрсөлдөөний тухай хуулийг хариуцсан эрх бүхий байгууллагуудын зүгээс ЖэйСиДеко Группийг өөрийн үйл ажиллагаа явуулж буй салбартаа давамгай байдал эзэмшдэг гэж үзэх нь байдаг.

Зах зээлд давамгай байдалтай байх/давамгай байдал эзэмшихийг хууль бусад тооцохгүй буюу хориглодоггүй. Харин давамгай байдлаа буруугаар ашиглахыг хориглодог.

Хэрэв ЖэйСиДеко нь аливаа бизнесийн салбарт эсвэл аливаа улсад давамгайл байдал эзэмшдэгт тооцогддог бол давамгайл байдал эзэмшдэггүй манай зах зээлийн хувьд хууль ёсны гэж тооцогдох байсан ч дараах үйлдлийг давамгайл байдлаа хууль бусаар ашигласанд гэж үзнэ. Үүнд:

- Түрэмгий үнэ тогтоох, тухайлбал өрсөлдөгчдийг зах зээлээс шахаж гаргах зорилгоор зах зээлийн нөхцөл байдалд огт нийцээгүй үнэ тогтоох (жишээ нь гудамжны тохижилтын хэрэгслийн гэрээг алдагдалтай байдлаар байгуулах, эсвэл өрсөлдөгчгүй болох зорилгоор үйлчлүүлэгчид үнэгүй зар сурталчилгаа хийж өгөх гэх мэт),
- Өрсөлдөгчийг шахан гаргах зорилгоор үнэнч хэрэглэгчийн хөнгөлөлт гэх мэтээр үйлчлүүлэгчид тусгай хөнгөлөлт өгөх, эсхүл
- Концессийн гэрээнд үндэсний болон/эсвэл Европын холбооны өрсөлдөөний асуудал хариуцсан байгууллагаас хориглосон заалтуудыг оруулах.

Үйл ажиллагаа явуулж буй улсын давамгайл байдлын талаарх хууль тогтоомжийг судалж мэдээрэй.

2. Ханган нийлүүлэгчидтэй тогтоосон өрсөлдөх харилцаа

Ханган нийлүүлэгчидтэй тогтоосон харилцаандаа ЖэйСиДеко Группийн ажилтнууд нь ханган нийлүүлэгч эдийн засгийн хувьд Группээс хараат болохгүй байх явдлыг хангаж ажиллах үүрэгтэй бөгөөд хэрэв өрсөлдөгчийн хангамжийн эх үүсвэр нь зах зээлд нэвтрэхэд голлох үүрэгтэй тохиолдолд ажилтнууд өрсөлдөгчийн уг эх үүсвэрийг булаах аливаа үйлдэл хийхгүй.

Хэрэв ханган нийлүүлэгч нь өрсөлдөгчид бусад эх үүсвэрээс олж авах боломжтой бүтээгдэхүүнийг үйлдвэрлэдэг тохиолдолд ханган нийлүүлэгчээс онцгой эрх олгохыг хүсэж болно. Гэхдээ онцгой эрх нь:

- Хугацаа болон газар зүйн байрлалын хувьд хязгаарлагдмал, бөгөөд
- Ханган нийлүүлэгчид зохих урамшуулал төлбөр/амлалт өгсний үндсэн дээр олгогдоно.

Ханган нийлүүлэгчдэд өрсөлдөөнтэй орчин бий болгоход нь дэмжлэг үзүүл. Өрсөлдөөн бүхий орчинд дараах зүйлс байна. Үүнд:

- Гурван жилээс хэтрэхгүй байх тогтмол давтамжтайгаар тендерийн урилга гаргах замаар ханган нийлүүлэгчид болон компанийн гаднах үйлчилгээ үзүүлэгчдийн тогтсон хугацаат үнэлгээ хийх,
- Боломж гарах бүрд тендерийн үзүүлэлтэд үндэслэн хамгийн цөөндөө гурван ханган нийлүүлэгчид тендерийн урилга илгээх, болон
- Ханган нийлүүлэгчийг сонгох болсон шалтгааныг заасан тодорхой, харьцуулсан баримт бичиг хадгалах.

Саналуудыг үнэ, бүтээгдэхүүн, үйлчилгээний чанар, хариуцлагатай байдал, үйлчилгээ, ЖэйСиДекогийн Ёс зүйн дүрмийг хүлээн зөвшөөрсөн байдал болон бусад холбогдох шалгуурууд гэх зэрэг тодорхой бодит шалгуурт үндэслэн үнэлж дүгнэ.

Таны компанид хашиж буй албан тушаалаас хамаарч, Групп компанийн ханган нийлүүлэгчтэй тогтоосон харилцаанд саад болж болзошгүй байдлаар аливаа ханган нийлүүлэгчид хувийн, санхүүгийн эсвэл бусад төрлийн шууд буюу шууд бус ашиг сонирхолтой байгаа тохиолдолд та өөрийг тань удирдах менежер мэдэгдээрэй.

Өрсөлдөөний тухай холбогдох хуулиудтай холбогдуулж ханган нийлүүлэгчдийн хувьд зөвхөн хүлээн зөвшөөрөгдөх хандлагыг нэвтрүүл. Ялангуяа та ханган нийлүүлэгч Группээс эсвэл Групп ханган нийлүүлэгчээс хараат болох нөхцөл байдал үүсгэхгүй байх явдлыг гүйцэлдүүлж ажиллах үүрэгтэй болно. Групп компанийн бизнес ханган нийлүүлэгчийн эргэлтийн хөрөнгийн 30-аас дээш хувийг эзэлж байгаа тохиолдолд онцгой анхааралтай байх шаардлагатай.

Хэрэв танд аливаа үйлдэл эргэлзээтэй санагдсан бол холбогдох зөвлөгөө өгч, таны зүгээс хуулийн дагуу хэрэгжүүлж болох үйлдлийг судлах үүрэгтэй харьяа Хууль зүйн хэлтэс, Групп компанийн Хууль зүйн хэлтсийн эсхүл бүсийн Хууль зүйн хэлтэстэй нэн даруй холбогдоорой.

3. Санхүү болон нягтлан бодох бүртгэлтэй холбогдох хуулиудыг дагаж мөрдөх

ЖэйСиДеко Групп нь:

- Найдвартай, үнэн зөв санхүүгийн болон нягтлан бодох бүртгэлийн мэдээллээр хангана. Энэ зорилгодоо хатуу чанд, үр дүнтэй дотоод хяналт хэрэгжүүлнэ.
- Харилцаа холбооны салбар, мэдээллийн нууцлал хамгаалах болон хувьцаа эзэмшигчдэд тэнцвэртэй хандахтай холбоотой хууль тогтоомжуудыг хүндэтгэн үзнэ.

Дээрх зорилтын хүрээнд:

1. Санхүү, нягтлан бодох бүртгэлийн тайлан гаргахад оролцдог Групп компанийн ажилтан бүр тухайн баримт бичгүүдэд тусгагдсан мэдээлэл цаг ямагт үнэн зөв байж, нягтлан бодох бүртгэлийн зарчим болон холбогдох бусад нягтлан бодох бүртгэлийн стандарт, журамтай нийцсэн байх явдлыг хангана. Групп компанийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн тайлан баримтууд үндсэн алдаагүй байх нь маш чухал юм.
2. Группийн компани тус бүрийн удирдлага үйл ажиллагаа явуулж буй улсын нягтлан бодох бүртгэл, санхүүгийн холбогдох хууль журмуудыг дагаж мөрдөх асуудлыг хариуцан ажиллана.

Компаниудын удирдлага дотоод хяналт болон Дотоод хяналтын гарын авлагыг дагаж мөрдөх асуудалд хяналт тавих үүрэгтэй. Үүнд нягтлан бодох бүртгэл, санхүүгийн бүхий л үйл ажиллагааг Групп компанийн тайлан, бүртгэлд үнэн зөвөөр тусгах явдлыг багтаана.

3. Санхүүгийн зах зээлд хяналт тавих чиг үүрэгтэй байгууллагуудаас гаргасан дүрмүүдийг дагаж биелүүлэхээс гадна ЖэйСиДеко Группийн бүх ажилтнууд өөрийн эрхэлж буй ажил эсвэл Группийн бусад ажилтнуудтай харилцахдаа нууц мэдээлэл олж авсан байх боломжтой бөгөөд нууц мэдээллийг ашиглах, задруулах нь холбогдох эрүүгийн хариуцлага хүлээхэд хүргэхээс гадна санхүүгийн зах зээл дэх Групп компанийн үнэлэмжид нөлөөлж эсвэл зарим этгээдэд хувьцаа эзэмшигчдээс илүү давуу тал олгож болзошгүй гэдгийг ойлгосон байвал зохино.

Тиймээс ажилтнууд Групп компанийн дотор гүйцэтгэж буй ажил үүргийнхээ дагуу олж авсан олон нийтэд нээлттэй болгоогүй бүх мэдээллийн нууцлалыг чанд хадгалж, цааш задруулахгүй байх үүрэгтэй.

4. Дотоод мэдээлэлд үндэслэн компанийн хувьцааг худалдах эсвэл худалдан авах- нийтэд хараахан нээлттэй болоогүй бөгөөд хувьцааны үнэд нөлөөлж болох мэдээлэл олж авсан этгээд ЖэйСиДеко ЭсЭй-ийн хувьцааг худалдаж авах эсвэл худалдах эсвэл энэ зорилгоор уг мэдээллийг гуравдагч этгээдэд дамжуулахыг хориглоно.

Дотоод мэдээллийг ашигласан этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.



Практик заавар:

Өндөр эрсдэлтэй нөхцөл байдал / хэрэгжүүлэх үйлдэл

Санхүү, нягтлан бодох бүртгэлийн талаарх холбогдох журмуудыг дагаж мөрдөх

1. Ерөнхий мэдээлэл

Группийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн мэдээллийг бэлтгэхэд оролцдог бол та тэдгээр баримт бичигт орсон мэдээлэл үнэн зөв байж, бүрэн дүүрэн, цогц байдлаар илэрхийлсэн эсэхийг нягтлах үүрэгтэй болно. Хэрэв та аливаа алдаа олж харсан ч тайланг засах боломжгүй тохиолдолд өөрийн удирдлагадаа мэдэгдэж алдааг засаж залруулах арга хэмжээ авах нь зүйтэй.

2. Нууц мэдээлэл


Та ажил үүргээ гүйцэтгэх үедээ Групп компани эсвэл ЖэйСиДеко Группийн аливаа компанийн ирээдүйн төлөв, нөхцөл байдал, маргаан шийдвэрлэх ажиллагаа, байгуулсан буюу байгуулах гэж буй гэрээ, худалдан авах төсөл эсвэл шилжүүлэх тодорхой үйл ажиллагаа, хамтарсан компанийн төслүүд, тулгарсан хүндрэл бэрхшээлийн талаарх мэдээлэл болон ерөнхийдөө ЖэйСиДеко ЭсЭй-ийн хувьцааны хөрөнгийн зах зээл дэх одоогийн болон ирээдүйн үнэд нөлөөлөх мэдээлэл авах болно. Хэрэв Групп эдгээр мэдээллийг олон нийтэд нээлттэй болгоогүй байгаа бол:

- › Та энэ мэдээллийг гуравдагч этгээдэд задруулахгүй байх үүрэгтэй,
- › Та өөрийн олж авсан мэдээллийг нийтэд нээлттэй болох хүртэл хугацаанд ЖэйСиДеко Группийн хувьцаатай холбоотой аливаа хэлцэлд зуучлагчаар дамжуулж эсхүл шууд худалдах, худалдан авах эрхээ хэрэгжүүлэх замаар оролцохгүй байх үүрэгтэй,
- › та нууц мэдээллийг тухайн мэдээллийг авах шаардлагатай этгээдэд дамжуулж болно. Та имэйл харилцаандаа, мөн галт тэрэг, нисэх онгоц, зоогийн газар гэх мэт олон нийтийн газар бусадтай ярилцах үедээ анхаарал болгоомжтой байх үүрэгтэй.

Франц Улсад санхүүгийн нууц мэдээллийг ашиглах, дамжуулах үйлдэлд хоёр хүртэл жилийн хорих ял болон хамгийн дээд тал нь хууль бусаар олсон орлогыг арав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний торгууль ногдуулдаг. Өөрөөр хэлбэл эдгээр үйлдэлд тухайн улсын хууль, журмын дагуу шийтгэл ногдуулах болно.

Ийм нууц мэдээллийг ЖэйСиДеко ЭсЭй-ийн Гүйцэтгэх зөвлөл эсвэл түүний шууд удирдлагаар нийтэд нээлттэй болгож болно.

Хэрэв танд аливаа үйлдэл эргэлзээтэй санагдсан бол холбогдох зөвлөгөө өгч, таны зүгээс хуулийн дагуу хэрэгжүүлж болох үйлдлийг судлах үүрэгтэй харьяа Хууль зүйн хэлтэс, Группийн Хууль зүйн хэлтсийн бүсийн Хууль зүйн хэлтэстэй нэн даруй холбогдоорой.



Группийн Ёс зүйт байдлын зарчмууд

Группийн бүх охин компани, түүний удирдлагад багтдаг бүх компаниуд, тэдгээрийн удирдлага Группийн Ёс зүйт байдлын зарчмуудыг холбогдох улсын хууль тогтоомжийн дагуу дагаж мөрдөх үүрэгтэй. Гэхдээ эдгээр зарчмыг зөрчсөн үйлдлийг Группийн Ёс зүйн хороо бус харин тухайн орон нутгийн салбар компанийн удирдлага авч үзэж, шийдвэрлэнэ.

1. Эрх бүхий байгууллагуудтай тогтоох бизнесийн харилцаа

1.1 Хууль, журмыг дагаж мөрдөх

Эрх бүхий байгууллагатай хийх гэж буй хэлцэлтэй тань холбоотой улс, муж, орон нутгийн бүх хууль, журам, практикыг судалж мэд. Та эдгээр хууль, журам, практикыг дагаж биелүүлэх үүрэгтэй.

Тендерийн үйл ажиллагаа, гэрээ хэлэлцэн тохиролцох, гэрээ байгуулах эсвэл үзүүлсэн үйлчилгээний төлбөрийг нэхэмжлэх явцад Эрх бүхий байгууллагуудтай тогтоох харилцааг нарийн журамласан байдаг.

1.2 Шударга ёсны зарчмыг баримтлах

Тухайн орон нутгийн Эрх бүхий байгууллагууд шинээр гэрээ, контракт байгуулах эрх олж авах нь ЖэйСиДеко Группийн цаашдын хөгжлийн зорилтыг биелүүлэхэд үндсэн чухал үүрэгтэй. Бид энэхүү зорилтыг үйл ажиллагаа явуулж буй улс, тухайн орон нутагт хууль бусад тооцогдох арга барилыг ашиглах замаар биелүүлж болохгүй юм. Нэн ялангуяа, компани, түүний ажилтнууд, эсвэл ханган нийлүүлэгчид болон орон нутгийн Эрх бүхий байгууллагын хооронд тодорхой гэрээтэй холбоотой аливаа сонирхлын зөрчлийг хатуу хориглоно.

Бүхий л гэрээ, тухайлбал төрийн байгууллагатай байгуулах гэрээг амжилттай байгуулах үндсэн шаардлага бол шударга өрсөлдөөн юм.

Тиймээс үйл ажиллагаа явуулж буй улс, орон нутагт төрийн байгууллагатай байгуулах гэрээтэй холбоотой дүрэм, журмыг зөрчиж болзошгүй аливаа үйлдэл хийхийг хориглоно.



Практик заавар:

Өндөр эрсдэлтэй нөхцөл байдал / хэрэгжүүлэх үйлдэл

Эрх бүхий байгууллагуудтай тогтоох бизнесийн харилцаа

ЖэйСиДеко Группийн ажилтнууд өдөр тутмын ажил үүргийн дагуу орон нутгийн Эрх бүхий байгууллагуудтай төрийн болон хувийн өмчийн талаар бизнесийн харилцаа тогтоож ажиллах болно.

Эрх бүхий байгууллагуудтай тогтоосон харилцаанд баримтлах хууль ёсны дүрэм нь ихэд нарийн түвэгтэйн дээр онцгой анхаарал, мэргэжлийн ур чадварыг байнга шаардаж байдаг.

1. Журмуудыг дагаж мөрдөх

Тухайн улсад бизнесийн үйл ажиллагаа явуулах боломжийг судлах ажлын нэг хэсэг болгож орон нутгийн Эрх бүхий байгууллагад хүсэлт гаргаж дагаж мөрдөх шаардлагатай хууль, журамтай (зөвлөх үйлчилгээний журам, тендерийн шалгуур гэх мэт) холбоотой баримт материал авч, анхааралтай уншиж танилц.

Хэрэв ийм баримт бичиг олж авахад хүндрэлтэй байгаа бол, өөрийн компанийн хууль зүйн баг буюу Хууль зүйн хэлтэс эсвэл Групп компанийн Хууль зүйн хэлтэстэй холбогдох шаардлагатай.

Зөвхөн барилгын гэрээ ч бус төрийн байгууллага зар сурталчилгааны талбай худалдаж авах асуудлыг тусгай журмаар зохицуулах боломжтой гэдгийг орон нутгийн Эрх бүхий байгууллагуудтай харилцахдаа анхаарах нь зүйтэй.

Хэрэв шаардлагатай бол та холбогдох хуулийн багийнхантай холбогдож тухайн баримт бичгүүдээс ойлгоогүй зүйлээ тайлбарлуулж болно. Цаашилбал та орон нутгийн Эрх бүхий байгууллагуудтай харилцахдаа дараах дүрмийг ягштал дагаж мөрдөх үүрэгтэй. Үүнд:

- Эрх бүхий байгууллагуудад бичгээр болон амаар хүргүүлсэн аливаа мэдээлэл нь бүрэн гүйцэд, үнэн зөв байна,
- Холбогдох Эрх бүхий байгууллагаас бичгээр зөвшөөрснөөс бусад тохиолдолд гэрээний нөхцөл, болзлуудыг их хэмжээгээр өөрчлөхийг зөвшөөрөхгүй.

2. Шударга ёсны зарчмыг баримтлах

ЖэйСи Деко Групп нь өөрийн оролцсон тендер, гэрээний шалгаруулалтад бусдаас ялгагдах бидний амжилтын цорын ганц хүчин зүйл болсон бүтээгдэхүүн, үйлчилгээнийхээ чанарт үндэслэн ялалт байгуулах бодлогыг баримталдаг.

Эрх бүхий байгууллагатай байгуулсан гэрээний харилцааны нэг хэсэг болохын хувьд та сонирхлын зөрчил эсвэл үүсэж болзошгүй сонирхлын зөрчлийг орон нутгийн хууль журмын дагуу шийдвэрлэх зорилгоор тухайн Эрх бүхий байгууллагын ажилтан болон ЖэйСиДеко Группийн хамтрагч, ханган нийлүүлэгч, агент, дистирбютр, зөвлөх нарын хооронд аливаа сонирхлын зөрчил байгаа эсэхийг нягтлах бүхий л боломжит арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

Үүний нэгэн адилаар ЖэйСиДеко Групп өөрийн эдийн засгийн ашиг сонирхолд дээд зэргээр нийцсэн үйл ажиллагаа явуулахад саад болох аливаа зөрчил үүсгэх үйлдэл хийхгүй байвал зохино.

Дараах тохиолдлуудад бидэнд гэрээний эрх олгох бүрэн эрхийг хэрэгжүүлэгч Эрх бүхий байгууллагын төрийн албан хаагчийн хамаатны хүмүүсийг ажилд авч болно. Үүнд:

- › Тухайн албан тушаал компанид бодит, үндэслэлтэйгээр зайлшгүй шаардлагатай,
- › Ажилд авсан этгээд нь уг албан үүргийг гүйцэтгэхэд шаардагдах чадвар/туршлагатай,
- › Санал болгож буй цалин урамшуулал нь компанийн бусад түүнтэй ижил түвшний туршлага, чадвартай ажилтанд олгож байгаатай тэнцүү.

Болгоомжлох үүднээс мөн хожим нь нотолгоо гаргаж өгөх нь хүндрэлтэй байна гэдгийг бодолцож, тухайн этгээд нь ажилд авах үед эдгээр шалгуурыг хангаж байсныг нотолсон баримтуудыг тэмдэглэлд хадгалж үлдээх шаардлагатай.

Төртэй байгуулах гэрээ болон/эсвэл Эрх бүхий байгууллагатай тогтоосон таны харилцааны талаар аливаа ярвигтай асуудал байгаа тохиолдолд Өөрийн шууд удирдлагадаа мэдэгдээрэй.

Хэрэв танд аливаа үйлдэл эргэлзээ төрүүлсэн бол холбогдох зөвлөгөө өгч, таны зүгээс хуулийн дагуу хэрэгжүүлж болох үйлдлийг судлах үүрэгтэй харьяа Хууль зүйн хэлтэс, Групп компанийн Хууль зүйн хэлтсийн таны ажиллаж буй бүс нутгийг хариуцсан Хууль зүйн хэлтэстэй нэн даруй холбогдоорой.

2. Үйлчлүүлэгчидтэй тогтоох бизнесийн харилцаа

ЖэйСиДеко Группийн гол үйлчлүүлэгчид нь бид өөрсдийн зар сурталчилгааны зай талбайгаа худалддаг зар сурталчилгаа гаргагч, зар сурталчилгааны агентлагууд, хэвлэл мэдээллийн ажилтнууд болон худалдан авах ажиллагааны төвлөрсөн байгууллагууд юм.

Бизнесийн ёс зүйн дүрмийг дагаж биелүүлэх үүднээс ажилтнууд үйлчлүүлэгчидтэй харилцахдаа өрсөлдөгчдийнхөө эдийн засагт эзлэх байр суурь, зах зээлийн хүчин чадлыг үл харгалзан гагцхүү хуулиар зөвшөөрөгдсөн арга хэлбэрийг ашиглах үүрэгтэй. Энэхүү дүрмийн зорилго нь бид одоогийн үйлчлүүлэгчидтэй тогтоосон харилцаагаа бататгах, шинэ үйлчлүүлэгчдийг татах, мөн зах зээл дэх өндөр ур чадвар, ёс зүйтэй өндөр чанараараа олж авсан Групп компанийн нэр хүндийг хадгалахад оршино.

2.1 Журмуудыг дагаж мөрдөх

Олон улсын хэмжээнд, эсхүл дотоодын зах зээлд үйлчлүүлэгчтэй гэрээ хийж байгаагаас үл хамааран та тухайн улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй бүх хууль, тогтоомжийг судалж, бүрэн гүйцэд дагаж мөрдөх үүрэгтэй.

2.2 Шударга ёсны зарчмыг баримтлах

Групп компанийн нэр төрийг үйлчлүүлэгчдийн өмнө унагаж болзошгүй аливаа үйлдэл хийхийг хориглоно. Ялангуяа, Групп компанийн ажилтнууд үүргийн харилцаа үүсгэх замаар үйлчлүүлэгчийн төлөөлөгчдөд ЖэйСиДеко Групптэй холбогдуулж гаргах шийдвэрт нь нөлөөлөх зорилгоор ашиг шууд буюу шууд бусаар санал болгохыг хориглоно.

2.3 Зар сурталчилгааны үйл ажиллагаанд хяналт тавих журам

ЖэйСиДеко Групп нь өөрийн сүлжээнд тавигдах эсвэл нэвтрүүлэх зар сурталчилгаатай холбогдуулж холбогдох хууль, журам мөн түүнчлэн энэхүү Дүрмийн зарчмуудыг дагаж мөрдөх бөгөөд ёс суртахуунтай, ёс журамтай байдлын стандартуудыг зөрчихөөс зайлсхийх үүрэгтэй. Үүний дагуу тодорхой сэдвийг (тухайлбал: архи, тамхи, нүцгэн бие/дотуур хувцас, хүчирхийлэл, шууд бус порнограф, бүтээгдэхүүний экологийн үр ашиг, театр/телевиз, видео тоглоом, насан хүрээгүй үзэгчдэд сэтгэл зүйд халтай бүтээгдэхүүн гэх мэт) харуулсан бүтээл, үзмэр үзүүлэнг маш анхааралтайгаар үнэлж дүгнэх шаардлагатай.

Ийм учраас үзмэр, дэлгэцийн агуулга, ялангуяа дээрх хэсэгт дурдсан сэдэвтэй холбоотой зүйлсэд хяналт тавих журам хэрэгжүүлэх зайлшгүй шаардлагатай. Тиймээс Групп үйл ажиллагаа явуулж буй улс бүртээ дээр дурдсан шалгууртай холбоотой шийдвэрийг баталгаажуулах хараат бус дотоодын тусгай хэлтэс, нэгж томилох, эсхүл бусад төрлийн комплайнсын механизмаар хяналт тавих шаардлагатай.

Ийм төрлийн дотоод хяналтын хороо нь тухайн зар сурталчилгааг гаргах, нэвтрүүлэх эсэх талаарх эцсийн, хараат бус шийдвэр гаргах эрхтэй байна.

2.4 Бартер

Үйлчилгээ (аялал гэх мэт) эсвэл хангамжийн (IT-ийн тоног төхөөрөмж гэх мэт) оронд зар сурталчилгааны зай, талбай худалдахыг онцгой практик гэж тооцож, хамгийн ил тод байх хатуу нөхцөлтэйгөөр (энэхүү үйлдлийн үндэслэл, үнийг нотолж, мөн нэхэмжлэл хүргүүлэхтэй холбоотой нягтлан бодох бүртгэл, татварын дүрэм, тухайлбал үүнд холбогдох орлого, зарлагын нягтлан бодох бүртгэлийн дүрмийг дагаж мөрдөнө) гүйцэтгэх шаардлагатай.

2.5 Санхүүжилтийн эх үүсвэр

Хууль бус үйл ажиллагаанаас олсон мөнгийг хууль ёсны эх үүсвэр ашиглаж нуусан эсвэл халхалсан үйл ажиллагаанаас бүрддэг мөнгө угаах ажиллагаа нь эрүүгийн хариуцлага хүлээлгэх үйлдэл юм.

Групп компани нь энэхүү эрсдэлийг бууруулах үүднээс зөвхөн хүлээн зөвшөөрөгдсөн нэр хүндтэй байгууллагуудтай хамтран ажилладаг. Хэрэв Групп бизнесийн шинэ хамтрагч сонгох шаардлагатай бол тухайн хамтрагч нь хэр нэр хүндтэй/найдвартай эсэхийг нягтлах зохих арга хэмжээ авах үүрэгтэй.



Практик заавар:

Өндөр эрсдэлтэй нөхцөл байдал / хэрэгжүүлэх үйлдэл

Үйлчлүүлэгчтэй тогтоосон бизнесийн харилцаа

1. Журмуудыг дагаж мөрдөх

Тодорхой бизнесийн үйл ажиллагаанд (жишээ нь, зар сурталчилгаа, худалдаатай холбоотой хууль, нэхэмжлэл хүргүүлэх дүрэм гэх мэт) хамааралтай хууль, журмуудын талаар олж мэдэх зорилгоор өөрийн харьяа Хууль зүйн хэлтэс, бүсийн Хууль зүйн хэлтэс эсвэл Группийн Хууль зүйн хэлтэстэй холбогдож зөвлөгөө авна уу. Зуучлагчдад хамааралтай хууль, журам улс орон бүрээс хамаарч харилцан адилгүй байна.

Жишээ нь, Франц Улсад зар сурталчилгааны агентлаг эсвэл бусад зуучлагч байгууллагаас (жишээ нь худалдан авалтын төв байгууллага) үзүүлсэн үйлчилгээний хөлсийг зар сурталчилгааг гаргасан хэвлэл мэдээллийн байгууллага бус харин гагцхүү зар сурталчилгаа гаргагч төлөх үүрэгтэй байдаг.

Энэхүү шаардлага нь зар сурталчилгааны агентлагт хэвлэл мэдээллийн байгууллагаар халхавчилсан мөнгөн төлбөр төлөхөөс сэргийлэх зорилготой юм. Энэхүү шаардлагыг биелүүлээгүй зөрчилд 1,500,000 евро хүртэл хэмжээний торгууль, мөнтөрийн байгууллагатай байгуулах гэрээний шалгаруулалтад оролцох эрхийг хасах шийтгэл ногдуулдаг (1993 оны 1-р сарын 29-ний өдрийн “Sapin” хууль).

Үйлчлүүлэгчтэй (жишээ нь худалдааны төлөөлөгчид, үйлчилгээ үзүүлэгчид, туслан гүйцэтгэгч, зуучлагч гэх мэт) харилцахад Групп компанийг төлөөлж буй этгээдүүд Группийн нэрийн өмнөөс гүйцэтгэж буй үйл ажиллагаандаа холбогдох хууль, журмыг дагаж мөрдөх явдлыг хангах талаар хүчин чармайлт гаргах үүрэгтэй.

Групп компанийн аливаа бусад компанийг бус зөвхөн та өөрийн ажиллаж буй компанийг төлөөлж, тус компанийн өмнө үүрэг хүлээх явдлыг хангах талаар хүчин чармайлт гаргах үүрэгтэй. Үүнтэй холбоотойгоор та тухайн байгууллаас тодорхой хэлцэл хийх эрх мэдэл, бүрэн эрх (жишээ нь итгэмжлэл, албан ёсны төлөөлөх эрх гэх мэт) шилжүүлэн авсан байх шаардлагатай.

Байгуулсан гэрээнүүд болон тэдгээрт холбогдох бусад баримт бичгүүдийг хадгалж үлдэх шаардлагатай.

2. Шударга ёсны зарчмыг баримтлах

Групп компанийг төлөөлж буй эсвэл төлөөлөн үйл ажиллагаа явуулж буй бүх гуравдагч талтай харилцахдаа бид тухайн харилцаанд баримтлах дотоод журам баталж, мөрдүүлэх явдлыг хангах үүрэгтэй бөгөөд энэхүү дотоод журам болон гадны зөвлөх ажиллуулах, үйл ажиллагааг зохион байгуулах журам нь тухайн тохиолдлоос хамаарч харилцан адилгүй байж болно.

Групп энэхүү үүргээ биелүүлэх явдлыг хангах үүрэгтэй.

Үйлчлүүлэгчийн төлөөлөгчийн үйл ажиллагаанд нөлөөлөх зорилгоор аливаа халхавчилсан урамшуулал, цалин санал болгохыг хориглоно. Хувийн хэвшил дэх авлигын хэрэгт эрүүгийн хариуцлага ногдуулна.

Бэлэг, зугаа цэнгэл санал болгоогүй байсан тохиолдолд гаргахгүй байх байсан шийдвэрт нөлөөлөх зорилгоор үйлчлүүлэгчид аливаа бэлэг, зугаа цэнгэл санал болгохгүй байх нь маш чухал юм. Нөлөө үзүүлэх зорилгоор аливаа бэлэг санал болгох буюу өгөхийг хориглоно. Ажилтнууд аливаа зохисгүй бэлэгтэй холбоотой асуудал, саналаа өөрийн шууд удирдлагын менежерт тавих үүрэгтэй.

Бэлэг, зугаа цэнгэлтэй (маш бага үнийн дүнтэйгээс бусад) холбоотой нягтлан бодох бүртгэлийн тэмдэглэлийг үнэн зөв хөтлөх шаардлагатай. Бичгээр үйлдсэн нотлох баримтуудыг хадгалуулах/архивлуулахаар холбогдох санхүүгийн хэлтэст хүргүүлнэ. Тухайн ажилтанд бэлэг, зугаа цэнгэл санал болгохыг зөвшөөрсөн менежер зөвшөөрөл өгсөн баримтуудыг хадгалж үлдэх үүрэгтэй.

Бэлэг

Үйлчлүүлэгчид санал болгох бэлэг өндөр үнэтэй байж болохгүй бөгөөд 130 (нэг зуун гуч) еврогоос хэтрэхгүй байна. Энэхүү мөнгөн дүнгээс өндөр үнэтэй бэлгийг таны шууд удирдлагын менежер зөвшөөрсөн байх шаардлагатай бөгөөд ажилтны оршин суугаа газар руу бус харин ажлын байр руу шууд илгээнэ.

Энтертайнмент

Групп компанийн худалдааны харилцааны тогтоох зорилгоор хийсэн аялал, шоу тоглолт гэх мэт энтертайнментийн зардлыг дараах төрлийн уулзалтын хүрээнд гаргахыг зөвшөөрнө. Үүнд:

- › Өндөр түвшний ажил хэргийн шинжтэй (бүтээгдэхүүн, зах зээлийн талаарх илтгэл танилцуулга гэх мэт...), эсвэл
- › шагнал, урамшууллын аялал гэх мэт дагалдах ажил хэргийн шинжтэй, гэхдээ зөвхөн урилгыг хувь хүнд бус хамт олонд (урилгыг ашиглаж ажил хэргийн холбоо тогтоох нэг төрөл эсвэл нэг хэсэг үйлчлүүлэгчдэд зориулсан байхаас бус ийм ажил хэргийн холбоо харилцаа тогтоох боломжгүй нэг эсвэл хэд хэдэн этгээдэд зориулаагүй байна) өгсөн байх шаардлагатай.

Зарим улсад бизнесийн бэлэг, энтертайнментийг арилжаа худалдааны практикт хүлээн зөвшөөрдөг. Харин бусад улсуудад бизнесийн бэлэг, энтертайнментийг арилжаа худалдааны практикт хүлээн зөвшөөрдөггүй. Тиймээс та бизнесийн бэлгийг тухайн улсын хуулиар зөвшөөрдөг эсэхийг нягтлах шаардлагатай.

3. Санхүүжилтийн эх үүсвэр

Мөнгө угаахтай тэмцэх тухай бүхий л холбогдох хууль, тогтоомжууд болон бэлэн мөнгөөр хийсэн гүйлгээ эсвэл бусад сэжигтэй үйл ажиллагааны тухай мэдүүлэг гаргахыг шаарддаг журмуудыг дагаж мөрдөөрэй. Хууль бус үйлдэл, ялангуяа ажил хэргийн хамтрагчийн бизнесийн үйл ажиллагаанд аливаа сэжигтэй зүйл байгаа эсэхийг тодорхойлох үүднээс төлбөр хэрхэн хийгдэж байгаад анхааралтай ханд.

Мөнгө угаах үйл ажиллагаа явагдаж байгааг илтгэх аливаа сэжүүр (жишээ нь гадаад улсаас үйл ажиллагаанд огт холбогдолгүй мөнгөн хөрөнгийг шилжүүлсэн хэвийн бус шилжүүлэг, гүйлгээг татварын таатай бодлоготой улсаас хийсэн, төлбөрийг шилжүүлэхдээ хэвийн бус арга хэлбэр, замыг ашигласан гэх мэт) байгаа эсэхийг байнга анхаарч ажигла.

Хэрэв танд аливаа үйлдэл эргэлзээтэй санагдсан бол холбогдох зөвлөгөө өгч, таны зүгээс хуулийн дагуу хэрэгжүүлж болох үйлдлийг судлах үүрэгтэй харьяа Хууль зүйн хэлтэс, Группийн Хууль зүйн хэлтсийн бүс нутаг хариуцсан Хууль зүйн хэлтэстэй нэн даруй холбогдоорой.

3. Ханган нийлүүлэгчидтэй тогтоох бизнесийн харилцаа

Групп компанийн ханган нийлүүлэгчидтэй үр ашигтай, урт хугацааны харилцаа тогтооход Группийн ёс зүйт байдлын зарчмыг дагаж биелүүлэх нь үндсэн чухал үүрэгтэй, мөн Группийн бүтээгдэхүүн, үйлчилгээний өндөр чанар, эдийн засгийн нөхцөлийг баталгаажуулахад ийм харилцаа холбоо зайлшгүй шаардлагатай юм.

Групп компанийн ёс зүйн зарчмууд нь Группийн зар сурталчилгааны тоног төхөөрөмжүүдийг суурилуулсан газар, барилгын өмчлөгчидтэй тогтоох харилцаанд мөн адил үйлчилнэ.

3.1 Журмуудыг дагаж мөрдөх

2016 оны 12-р сарын 9-ний өдрийн хуульд (Sapin II) заасны дагуу та үйл ажиллагаа явуулж буй улсын Групп компанийн ханган нийлүүлэгчидтэй тогтоох харилцаатай холбоотой хууль, журмуудыг дагаж мөрдөнө. Мөн түүнчлэн ханган нийлүүлэгчидтэй байгуулсан гэрээний нөхцөл, болзлуудыг биелүүлж ажиллах үүрэгтэй.

Барилга байгууламж, газрын “түрээслүүлэгчид” эсвэл өмчлөгчидтэй тогтоох харилцааны хүрээнд ихэнх улс орнууд хувийн эзэмшлийн газар дээр байрласан зар сурталчилгааны байгууламжуудад хамаарах үндэсний хэмжээнд болон орон нутгийн хэмжээнд дагаж мөрдөх төрөл бүрийн хууль, журамтай байдаг. Тиймээс Групп компанийн ажилтнууд тухайн улсад гадна талбайд зар зар сурталчилгаа эсвэл нэвтрүүлэг гаргахад дагаж мөрдөх практик, дүрэм журмыг мэдэж байх үүднээс холбогдох хот суурин газрын холбогдох дүрэм, журмыг сайтар судалж мэдэх шаардлагатай.

3.2 Шударга ёсны зарчмуудыг баримтлах

Ханган нийлүүлэгчидтэй харилцахдаа Группийн нэр хүндийг унагасан үйлдэл гаргахыг хориглоно. Ялангуяа, зуучлагчаар дамжуулж шууд буюу шууд бусар аливаа халхавчилсан төлбөр урамшуулал, бэлэг, урилга өгөх саналыг хүлээн авах, эсвэл эдгээрийг шаардахыг хориглоно. Ийм санал нь таны үнэлгээ, шийдвэрт нөлөөлөх гэсэн далд зорилготой байж болно.

Идэвхтэй, идэвхгүйгээс үл хамаарч, хувийн хэвшил үйлдэгдсэн авлигын хэрэгт эрүүгийн хариуцлага хүлээлгэхийг санаарай.

3.3 Ханган нийлүүлэгчид Группийн ёс зүйн дүрмийг дагаж мөрдөх

Группийн ханган нийлүүлэгчид, үйлчилгээ үзүүлэгчид Группийн шударга ёсны зарчмыг хүндэтгэн дагах үүрэгтэй. Үүнийг биелүүлэхийн тулд Группийн зүгээс томоохон ханган нийлүүлэгчид, үйлчилгээ үзүүлэгчидтэй байгуулах гэрээнд дараах заалтуудыг тусгасан байна. Үүнд:

- I) Группийн ёс зүйн дүрмийг дагаж мөрдөх үүрэгтэй, бөгөөд
- II) эдгээр дүрмийг зөрчих нь гэрээг цуцлах үндэслэл болно гэдгийг хүлээн зөвшөөрнө.



Практик заавар:

Өндөр эрсдэлтэй нөхцөл байдал / хэрэгжүүлэх үйлдэл

Ханган нийлүүлэгчидтэй тогтоох бизнесийн харилцаа

1. Журмуудыг дагаж мөрдөх

Ханган нийлүүлэгчидтэй байгуулах гэрээний худалдааны нөхцөлийг анхааралтай уншиж танилц. Мөн түүнчлэн өөрчлөлт оруулах шаардлагатай хэсгүүдийн талаар өөрийн харьяа Хууль зүйн хэлтэс, бүсийн Хууль зүйн хэлтэс болон зөвлөхүүдтэй холбогдож зөвлөлд. Гэрээг хэлэлцэж тохиролцсоны дараа гэрээний үүргээ биелүүлж, ханган нийлүүлэгч ч гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх явдлыг хангаж ажилла.

Группийн аливаа бусад компанийг бус зөвхөн та өөрийн ажиллаж буй компанийг өмнө хүлээх үүргээ биелүүл. Ийм төрлийн гэрээ байгуулахдаа шаардлагатай зөвшөөрөл авсан буюу ийм үйлдэл хийх бүрэн эрхтэй (жишээ нь итгэмжлэл, заавар гэх мэт) байх шаардлагатай.

Гэрээний эх хувь болон дагалдах бусад баримт бичгүүдийг авч хадгал.

Зар сурталчилгааны зай талбайг түрээслүүлэгч хувь хүн, компани, Эрх бүхий байгууллагын түрээслүүлэгчтэй харилцах харилцааны хүрээнд Групп компанийн зар сурталчилгааг тасралтгүй үргэлжлүүлэх зорилгоор дараах арга хэмжээг авна. Үүнд:

- Групп компани зар сурталчилгааны тоног төхөөрөмж байрлуулахаар төлөвлөж буй хот тус бүрийн холбогдох дүрэм, журмыг судалж мэд.
- Эрх олгосон этгээд тухайн эрхийг олгох эрхтэй хууль ёсны өмчлөгч мөн эсэхийг нягтал.
- Хувийн эзэмшлийн газарт байрласан түрээсийн зай талбайтай холбоотой түрээсийн гэрээнд хамааралтай орон нутаг /муж/ болон үндэсний хэмжээнд мөрдөгдөж буй хууль, журмыг хүндэтгэн, дагаж мөрд.
- Холбогдох эрх бүхий байгууллагуудад бүхий л шаардлагатай зөвшөөрөл авах хүсэлт гарга.

2. Шударга ёсны зарчмыг баримтлах

Ханган нийлүүлэгчээс шууд буюу шууд бус халхавчилсан болон аливаа бусад хэлбэрийн төлбөрийг хүлээж авах, бусдаас шаардахыг хориглоно. Энэ асуудлыг (бэлэг, урилга гэх мэт) дараах байдлаар шийдвэрлэнэ.

Групп компани үүргээ биелүүлэх болон гэрээнд заасан хугацааг дагаж мөрдөх явдлыг ханга.

3. Ханган нийлүүлэгчид Группийн ёс зүйн дүрмийг дагаж мөрдөх

Бэлэг, урилга

Та 70 (дал) еврогоос дээш үнэтэй эсвэл тухайн улсын хуулиар бага үнэ тогтоосон бол түүнээс давсан үнэ бүхий бэлэг авч болохгүй. Энэхүү мөнгөн дүнгээс өндөр үнэтэй бэлгийг авахаас татгалзаж, ханган нийлүүлэгчид буцаана. Хэрэв бэлэг авахаас татгалзах нь бизнест таагүй нөхцөл байдал үүсгэхээр бол өөрийн шууд удирдлагадаа мэдэгд. Шууд удирдлага тань тухайн бэлэг/урилгыг хүлээж авах эсэх, хэлтсийнхэнтэй хуваах, эсвэл ЖэйСиДеко Группийн дэмжлэг үзүүлдэг холбоонд тэнцүү хэмжээгээр төлбөр төлөх эсэх асуудлыг шийдвэрлэнэ.

Цаашилбал, бэлгийг өөрийн оршин суугаа газартаа бус зөвхөн ажлын байранд хүлээн авна.

Бэлэн мөнгө эсвэл бэлэн мөнгөтэй адилтгах зүйлээр илэрхийлсэн бэлэг авахыг хориглоно.

Авбал зохих арга хэмжээнүүд

Ханган нийлүүлэгчийн нэр хүнд, өмнө нь эрхэлж байсан үйл ажиллагаа тогтмол нягтлан судалж байх шаардлагатай. Нэн ялангуяа Группийн ёс зүйн дүрэмд харш үйл ажиллагааг (тухайлбал авлига, хүүхдийн хөдөлмөр) хүлээн зөвшөөрдөг улс оронд хянан шалгаж байх нь зүйтэй.

Томоохон ханган нийлүүлэгч болон шинэ ханган нийлүүлэгчидтэй байгуулсан гэрээнд ЖэйСиДеко Группийн Ханган нийлүүлэгчдийн үйл ажиллагааны дүрмийг (Группийн дотоод сүлжээнээс авах боломжтой) хавсарга.

Өөрийг тань удирдах менежерт аливаа ханган нийлүүлэгчтэй холбоотойгоор үүсэж болзошгүй хувийн сонирхлын зөрчлийн талаар мэдэгд.

Хэрэв танд аливаа үйлдэл эргэлзээтэй санагдсан бол холбогдох зөвлөгөө өгч, таны зүгээс хуулийн дагуу хэрэгжүүлж болох үйлдлийг судлах үүрэгтэй харьяа Хууль зүйн хэлтэс, Группийн Хууль зүйн хэлтсийн бүсийн Хууль зүйн хэлтэстэй нэн даруй холбогдоорой.

4. ЖэйСиДеко Группийн ажилтнуудын эрх, үүрэг

4.1 Нийгмийн үндсэн үнэт зүйлс

ЖэйСиДеко Групп нь ажилтнуудаа аливаа хэлбэрийн алагчлал гадуурхалгүй, эрүүл, аюулгүй, бүтээлч ажиллах орчноор хангахын төлөө ажилладаг бөгөөд энэхүү асуудлаар хүлээх үүргээ ЖэйСиДеко Группийн Нийгмийн суурь үнэт зүйлсийн Олон улсын дүрэмд тусгасан болно. Энэхүү Дүрмийг Группийн дотоод сүлжээ, Хүний нөөцийн хэлтэс эсвэл Тогтвортой хөгжил ба чанарын хэлтсээс авах боломжтой.

4.2 Ажилтнуудын үүрэг

4.2.1 Ёс журам ба үнэн шударга байдал

Ажилтан бүр нь ЖэйСиДекогийн шударга журамт байдал, нэр төрд тус тусын хэмжээнд хувь нэмэр оруулж байдаг бөгөөд иймээс хамт ажиллагч болон компаниас гадуурх хүмүүстэй харилцах харилцаандаа эдгээр үнэт зүйлсийг хүндэтгэн дагах үүрэгтэй. Ялангуяа Групп нь өрсөлдөх чадвар, бизнесийн амжилтад үндсэн чухал нөлөө үзүүлэх төрөл бүрийн хөрөнгө эзэмшдэг бөгөөд ажилтнууд өөрийн эзэмшилд байгаа компанийн хөрөнгийг хамгаалах үүрэгтэй.

4.2.2 Мэдээллийн нууцлал

Санхүүгийн мэдээлэл, техникийн өгөгдөл, бүтээгдэхүүн, гэрээ, нөү-хаутай холбоотой мэдээлэл гэх зэрэг бүх мэдээлэл нь Групп компанийн өмч болно. Эдгээр мэдээллийн ихэнх нь нууц бөгөөд дээд удирдлагаас урьдчилан зөвшөөрөл авалгүйгээр цааш задруулахыг хориглоно. ЖэйСиДеко Группийн ажилтнууд өөрсдийн нэвтрэх/авах боломжтой мэдээллийн нууцлалыг хадгалах үүрэгтэй.

4.2.3 Гуравдагч этгээдийн оюуны өмчийн эрхийг хүндэтгэх

Та өөрийн үйл ажиллагааны хүрээнд гуравдагч талын өмч болох аливаа зохиогчийн эрх, барааны тэмдэг, патент, загвар, дизайнтай холбоотой оюуны өмчийн эрхийг зөрчихгүй байх асуудлыг анхаарч ажиллах үүрэгтэй.

Гуравдагч талын компьютерийн програм хангамжийг зохих зөвшөөрөлгүйгээр ашиглах, хуулбарлахыг хориглоно.

4.2.4 Мэдээллийн систем ашиглах

Хэрэглэгч бүр өөрийн мэдэлд байгаа тоног хэрэгслийг (жишээ нь компьютер, ухаалаг утас, таблет, принтер гэх мэт) ариг гамтай ашиглах үүрэгтэй. Эвдэрч, гэмтэх, хулгайлагдах эсвэл гуравдагч этгээд аливаа зөвшөөрөгдөөгүй байдлаар ашиглахаас сэргийлэх бүх талын арга хэмжээ авах үүрэгтэй. Хэрэглэгч эдгээр хэрэгслүүдэд хүлээн авч, хадгалсан мэдээллийг хамгаалах үүрэгтэй бөгөөд ажил хэргийн бус шалтгаанаар эдгээр системийн тохиргоог өөрчлөх болон тохирохгүй програм хангамж суулгах эрхгүй байна.

4.2.5 Мэдээллийн хөрөнгө хамгаалах

Мэдээллийн хөрөнгө гэдэг ойлголт нь зохион байгуулалтад оруулсан буюу оруулаагүй, Групп компанийн үйлчилгээг явуулахад шаардлагатай бүх төрлийн компьютерээр боловсруулсан мэдээлэл, мэдээллийн санг хэлнэ. Үүнд манай веб хуудсанд байршуулсан мэдээллийн сан, үйлчлүүлэгч болон ханган нийлүүлэгчийн мэдээллийн сан, имэйл хаягууд гэх зэргийг багтаана.

Ажилтан бүр бүхий л үед өөрийн ажил үүргээ гүйцэтгэхдээ ажиллуулж буй эсвэл ашиглаж буй мэдээлэл, мэдээллийн сангийн нууцлалыг хадгалах үүрэгтэй. Ялангуяа, ажилтан нь хэрэглэгчийн бүртгэл, код, нэвтрэх нууц үг эсвэл аливаа бусад нэвтрэх эрх олгох хяналтын системийн нууцлалыг хадгалж, имэйл болон олон нийтийн цахим сүлжээгээр дамжуулах мэдээлэлд анхааралтай хандах хэрэгтэй.



Практик заавар:

Өндөр эрсдэлтэй нөхцөл байдал / хэрэгжүүлэх үйлдэл

ЖэйСиДеко Групп Компанийн ажилтнуудын эрх, үүрэг

1. Эрүүл ахуй, аюулгүй байдал

Бүхий л ажилтнууд болоод таны удирдлагад ажиллаж буй түр ажилтнуудын эрүүл ахуй, аюулгүй байдлыг хангах бүхий л шаардлагатай арга хэмжээг авах шаардлагатай. Тодруулбал ажлын байран дахь осол гэмтлээс сэргийлэх, мэдээлэл, сургалт явуулах болон тохиромжтой зохих байгуулалтад оруулах, зохистой аргачлал ашиглах арга хэмжээг авч хэрэгжүүлэх үүрэгтэй болно.

2. Ёс журам ба үнэнч шударга байдал

ЖэйСиДекогийн өмчид хамаарах эд хөрөнгө, тухайлбал тоног төхөөрөмж, систем, багаж хэрэгсэл, төлбөрийн карт, компьютерийн хэрэгсэл (жишээ нь интернет, дотоод мессежний систем эсвэл бусад зүйлс) болон бусад хангамжийг ашиглахдаа Групп компаниас баталсан зааварчилгааг дагаж биелүүлэх явдлыг ханга.

Та аливаа өөрийн олон нийтийн, буяны байгууллага эсвэл улс төрийн, шашны албан тушаалтныг сурталчлах, ивээн тэтгэх, дэмжих хувийн үйл ажиллагаа ЖэйСиДеко Групптэй аливаа байдлаар холбогдох, хамаарахгүй байх явдлыг хангаж ажиллах үүрэгтэй. Үүний адилаар та Групп компани дахь статус эсвэл албан тушаалаа шууд буюу шууд бусаар хувийн ашиг хонжоо эсвэл мөнгөн орлого олох зорилгоор ашиглах эрхгүй.

ЖэйСиДеко Группийн зүгээс зөвшөөрсөн ашгийн бус байгууллагыг сурталчлах, ивээн тэтгэх, дэмжих үйл ажиллагаатай холбоотой аливаа зардал хуулийн дагуу бөгөөд Группээс хүлээн авсан дэмжлэг, тулалцаатай нийцсэн байх явдлыг хангаарай.

3. Хүлээн авсан, задруулсан мэдээллийн нууцлал

Та өдөр тутмын үйл ажиллагааны явцдаа гагцхүү шаардлагатай тохиолдолд гуравдагч талд мэдээлэл (нөү-хау, үйлдвэрлэлийн процесс, ЖэйСиДеко Группийн бизнесийн үйл ажиллагаатай холбоотой авсан оюуны өмчийн эрх гэх мэт) задруулна гэдгийг санах үүрэгтэй. Ялангуяа, задруулах шаардлагатай бөгөөд гуравдагч талтай тогтоосон харилцааны талаарх ЖэйСиДеко Групптэй холбоотой аливаа болон бүх нууц эсвэл нууцлалтай мэдээллийг Хууль зүйн хэлтсээс баталсан, тухайн мэдээллийг хамгаалах нөхцөл, болзлуудыг тодорхойлсон нууцлал хадгалах гэрээний дагуу мэдээлэл, өгөгдлийг задруулж болно. Гуравдагч этгээдэд нууцлалтай мэдээллийг өгөхдөө мэдээллийг жагсааж, нарийвчлан тодорхойлж, нууцлал бүхий мэдээлэл гэдгийг тодотгосны дараа задруулж болно.


Гуравдагч талаас хүлээн авсан нууц мэдээллийг байгууллагын дотор тухайн мэдээллийг авах шаардлагатай этгээд эсвэл Группийн Ерөнхий менежментээс сонгосон зөвлөхөд задруулах бөгөөд тухайн этгээд эсвэл гуравдагч этгээдэд тэдэнд хамаарах нууцлал хадгалах үүргийн талаар мэдэгдэх үүрэгтэй.

4. Гуравдагч этгээдийн оюуны өмчийн эрхийг зөрчих

Үйл ажиллагаа явуулж буй улсын барааны тэмдэг, патент, зураг төсөл, ашигтай загвар, зохиогчийн эрхийн тухай холбогдох хуулийг судалж мэд. Ихэнх улсад гуравдагч этгээдийн оюуны өмчийн эрхийн зөрчилд холбогдуулж зөрчил гаргасан талд иргэний болон эрүүгийн хариуцлага хүлээлгэдэг.

Аливаа програм хангамж, тоон системийг хууль бусаар ашиглах үйлдэл гаргахаас зайлсхий. Үүнд тухайлбал гуравдагч этгээдийн загвар, лого, бусад сурталчилгааны зүйлс, мөн аудио өмчийг урьдчилан авсан зохих зөвшөөрөлгүйгээр ашиглахыг хориглох бөгөөд зөвхөн үүгээр хязгаарлагдахгүй.

Хэрэв танд аливаа үйлдэл эргэлзээтэй санагдсан бол холбогдох зөвлөгөө өгч, таны зүгээс хуулийн дагуу хэрэгжүүлж болох үйлдлийг судлах үүрэгтэй харьяа Хууль зүйн хэлтэс, Группийн Хууль зүйн хэлтсийн бүсийн Хууль зүйн хэлтэстэй нэн даруй холбогдоорой.



IV | Группийн Ёс зүйн хороо

Группийн Ёс зүйн хороо нь Ёс зүйн үндсэн дүрэм болон дараах асуудлуудтай холбоотой зөрчлүүдийг хариуцдаг. Үүнд:

- › Авлига ба албан тушаалын эрх мэдлээ урвуулан ашиглахыг хориглох,
- › Чөлөөт өрсөлдөөний дүрмийг дагаж мөрдөх, болон
- › Санхүү, нягтлан бодох бүртгэлийн журмуудыг дагаж биелүүлэх.

1. Асуудлыг Группийн Ёс зүйн хороонд танилцуулах

Ёс зүйн үндсэн дүрмийн зөрчлийн талаар олж мэдсэн аливаа ажилтан өөрийн шууд удирдлага болох захирал эсвэл тухайн улсыг хариуцсан Ерөнхий менежерт асуудлыг мэдээлэх нь түүнд аливаа хүндрэл бий болгоно, эсхүл зохих арга хэмжээ авахгүй байх магадлалтай гэж үзсэн нөхцөлд Группийн Ёс зүйн хороонд тус мэдээллийг хүргүүлнэ.

Ёс зүйн хороонд ирүүлсэн мэдээлэл нь:

- › Группэд нийгмийн хариуцлага болон ёс зүйн журмуудаа сайжруулах боломж олгодог, бөгөөд
- › урт хугацаандаа Группийн эрх ашгийг хамгаалж байдаг.

Группийн дотоод сүлжээнд байршуулсан Группийн ёс зүйн мэдээллийн журам нь дэлхийн аль ч улсад буй ЖэйСиДеко Группийн аливаа ажилтанд гарсан байж болзошгүй зөрчлийн талаар Группийн Ёс зүйн хорооны Хэрэг эрхлэх газарт шууд мэдээлэх боломж олгодог.

Энэхүү ёс зүйн мэдээллийн дагуу өгсөн мэдээлэл нь арга хэмжээ авах боломжийг олгохуйц хэмжээнд үнэн зөв, хангалттай тодорхой байх шаардлагатай. Группийн Ёс зүйн хороо таамагласан мэдээлэл эсвэл шаардлагад нийцэх тодорхой мэдээлэл тусгаагүй тодорхой бус мэдээллийг судалж, нягтлахгүй.

Ажилтан бүр мэдээлэх журамд үнэ төлбөргүйгээр, нууцлалтай байдлаар нэвтрэх боломжтой. Тухайн журам нь дараахаас бүрдэнэ. Үүнд:

- › Групп үйл ажиллагаа явуулж буй улс бүрийн вебсайтны эсвэл экстранетийн нүүр хуудаснаас нэвтрэх боломжтой цахим маягт, болон

➤ Ёс зүйн мэдээллийн утас: 33 (0)1 30 79 79 11 (Францад).

Группийн Ёс зүйн хорооны хэрэг эрхлэх газар нь Группийн Ерөнхий зөвлөх болон Ерөнхий зөвлөхийн Орлогчийн удирдлагад багтана. Тэдэнтэй 33 (0)1 30 79 79 11 (France) дугаарын утсаар эсвэл comite.ethique@jcdecieux.com гэсэн имэйл хаягаар холбогдох боломжтой.

Зарчмын хувьд мэдээлэл дамжуулж буй этгээд өөрийн нэрийг дурдах үүрэгтэй.

Мэдээлэл өгсөн хүний нэрийг нууцалж, нэрийг мэдэгдэхгүй байх явдлыг хангана.

Гэхдээ, хэрэв мэдээлэл дамжуулж буй этгээд нэрээ мэдэгдэхийг хүсэхгүй тохиолдолд Ёс зүйн хороонд ирүүлсэн мэдээлэлдээ нэрээ мэдэгдэхгүй байх шалтгаанаа дурдсан байна. Энэ тохиолдолд Группийн Ёс зүйн хороо мэдээлсэн асуудал хэр ноцтой болох, мөн өгсөн мэдээлэл хэр үндэслэлтэй/тодорхойг сайтар нягталсны үндсэн дээр тухайн мэдээлэлд дурдсан үйлдлүүдийг цаашид судлах эсэхийг шийднэ.

2. Мэдээлэл өгсөн ажилтныг хамгаалах

ЖэйСиДеко Групп ёс зүйн асуудлыг түргэн шуурхай, үр дүнтэй шийдвэрлэх нь ёс зүйн үйл ажиллагааны үндсэн ажиллагаа гэж үздэг. Тиймээс, Франц Улсын хуулийн (2007 оны 11-р сарын 13-ны өдрийн) дагуу, мөн үйл ажиллагаа явуулж буй зарим улсын хуулийн дагуу Групп нь өгсөн баримтууд нь үнэн зөв биш эсвэл цаашид аливаа алхам хэрэгжүүлэх шаардлагагүй байсан тохиолдолд ч энэхүү журмын хүрээнд шударгаар мэдээлэл өгсөн ажилтны эсрэг аливаа шийтгэл, сануулга, хориг, статус өөрчлөх, хавчиж гадуурхах үйлдэл, мөн аливаа хариу арга хэмжээ авахгүй буюу ийм үйлдэл гаргахыг зөвшөөрөхгүй.

Группийн Ёс зүйн хороонд мэдээлэл өгөх журмыг сайн дурын үндсэн дээр ашиглана. Тус хорооны бүрэн эрхэд хамаарах баримтын талаар олж мэдсэн боловч мэдээлээгүй ажилтнуудад аливаа сахилгын шийтгэл ногдуулахгүй.

Үүний эсрэгээр, энэхүү журмыг буруугаар ашигласан ажилтнуудад сахилгын шийтгэл хүлээлгэх буюу хуулийн дагуу арга хэмжээ авна.

3. Хувийн мэдээллийг хамгаалах

ЖэйСиДеко ЭсЭй-ийн хэрэгжүүлж буй шүгэл үлээх систем нь мэдээлэл цуглуулах үүрэг гүйцэтгэдэг. Групп үйл ажиллагаа явуулж буй ихэнх улс, тухайлбал Европын холбооны мэдээлэл хамгаалах тухай холбогдох хуульд заасан шүгэл үлээх журмын дагуу нэр холбогдсон этгээд нь тухайн мэдээллийг өгсөн эсвэл мэдээлэлд буруутайд тооцогдсон эсэхээс үл хамаарч Группийн Ёс зүйн хорооны Хэрэг эрхлэх газрын comite.ethique@jcdecieux.com хаяг руу биеийн байцаалтын хуулбараа хавсаргасан имэйл илгээх замаар өөрт хамааралтай мэдээллийг авах эрхтэй байна. Алдаатай, бүрэн бус, худал эсвэл хуучин мэдээлэлд өөрчлөлт оруулах хүсэлт гаргахад дээрхтэй адил журам баримтална.

Франц Улсын мэдээлэл хамгаалах байгууллагад (Commission Nationale de l'Informatique et des Libertés) энэхүү шүгэл үлээх системийн талаар мэдэгдсэн болно.

4. Группийн Ёс зүйн хорооны гүйцэтгэх үүрэг

Группийн Ёс зүйн хороо нь:

- ЖэйСиДеко Группийн Ёс зүйн үндсэн дүрэмтэй холбоотой асуудлыг шийдвэрлэх болон шаардлагатай гэж үзсэн асуудлаар Гүйцэтгэх зөвлөлд санал зөвлөмж хүргүүлнэ,
- Ажилтны зүгээс шударгаар мэдээлсэн Ёс зүйн үндсэн дүрэмтэй харшилсан нөхцөл байдлын талаарх мэдээллийг маш нууцлалтайгаар нягталж шалгах бөгөөд шаардлагатай гэж үзсэн санал зөвлөмжийг гаргаж, мэдээлэлд холбогдох хариу өгнө,
- Дүрэмд өөрчлөлт оруулах санал гаргана.

5. Группийн Ёс зүйн хорооны гишүүд, тэдгээрийг сонгох

Группийн Ёс зүйн хороо гурван гишүүнтэй байна. Тэдгээр нь ЖэйСиДеко ЭсЭй-ийн Удирдах зөвлөлийн Аудитын хорооны дарга, ЖэйСиДеко ЭсЭй-ийн Удирдах зөвлөлийн Цалин урамшуулал, нэр дэвшүүлэх хорооны дарга, ЖэйСиДеко ЭсЭй-ийн Дотоод аудитын захирал нар болно. ЖэйСиДеко ЭсЭй-д тухайн албан тушаалыг хаших хугацаандаа Хорооны гишүүний үүргийг гүйцэтгэнэ.

Аудитын хорооны дарга Группийн Ёс зүйн хорооны даргын үүргийг гүйцэтгэнэ.

6. Группийн Ёс зүйн хорооны үйл ажиллагаа

Группийн Ёс зүйн хороо жилд нэгээс доошгүй удаа хуралдана. Ёс зүйн үндсэн дүрмийг зөрчсөн үйл явдлын талаар мэдээлсэнтэй холбогдуулж хорооны Дарга зарласан үед буюу хорооны Даргын зүгээс шаардлагатай гэж үзсэн тохиолдолд хорооны хурал хийж болно. Хэрэв шаардлагатай бол хурлыг утсаар эсвэл видео хэлбэрээр хийнэ.

Группийн Ёс зүйн хороо нь Ёс зүйн үндсэн дүрмийг зөрчсөн үлдэлтэй холбоотой мэдээллийн мөрөөр баримт олж цуглуулах, мөрдлөг шалгалт хийх бүрэн эрхтэй байна. Тодруулбал дотоод аудитын шалгалт хийх хүсэлт гаргах, албан хэргээр зорчих, шаардлагатай гэж үзсэн этгээд, тухайлбал ЖэйСиДеко Группийн ажилтнаас асууж тодруулах, мөн засаж залруулах арга хэмжээ санал болгох эрхтэй.


Группийн Ёс зүйн хорооны гишүүдийг бусад этгээд төлөөлөхгүй.

Группийн Ёс зүйн хороо хуралд оролцож буй гишүүдийн олонхын саналаар шийдвэр гаргана. Хуралд утсаар эсвэл видео хэлбэрээр оролцож байгаа гишүүдийг хуралд оролцсонд тооцно. Санал тэнцсэн тохиолдолд Дарга шийдвэрлэх санал өгнө.

7. Гүйцэтгэх зөвлөлд мэдээлэх

Группийн Ёс зүйн хороо нь Ёс зүйн үндсэн дүрэмд харшилсан асуудлыг засаж арилгах санал зөвлөмж хүргүүлэх зорилгоор хэдийд ч, өөрийн боломжтой үедээ Гүйцэтгэх зөвлөлд хандаж болно. Группийн Ёс зүйн хороо холбогдох тухайн жилд аливаа мэдээлэл авсан бол тухайн асуудлын талаарх жилийн тайланг Гүйцэтгэх зөвлөлд жил бүр хүргүүлнэ.





Ёс зүйн дүрэм

2018 оны хувилбар

JCDecaux